
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2020 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:

Аймгийн Засаг даргын зөвлөл 1 дүгээр сарын 2-нд хуралдаж, Ховд аймгаас Улсын хошой аварга малчин өрх, Улсын аварга малчин өрх, Улсын аварга тариаланч шалгаруулах тухай асуудлуудыг хэлэлцлээ. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 338 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын аварга малчин өрх, Улсын хошой аварга малчин өрх шалгаруулах” журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн дагуу сумдын ЗДТГ-аас аймгийн ХХААГ-т ирүүлсэн тодорхойлолтыг хэлэлцэж, нэр бүхий малчин өрхүүдийн тодорхойлолтыг Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Ховд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2019 оны ажлын тайланг танилцуулах, сумдын өвөлжилтийн байдалтай газар дээр нь танилцах, сум орон нутгийн өнгөрсөн онд хэрэгжүүлсэн ажилд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, иргэдийн санал хүсэлтийг сонсох зорилгоор аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч нар, ЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг 1 дүгээр сарын 17-25-ны өдрүүдэд хөдөөгийн 17 сумдад ажиллаж, сумын ИТХ, Засаг дарга түүний Тамгын газар, бусад төсөвт байгууллагуудын дарга эрхлэгч, төрийн албан хаагчидтай уулзалт хийж аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжилт, хүрсэн үр дүн, цаашдын зорилтын талаар мэдээлэл хийлээ. Мөн сумдын төрийн байгууллагын ажил, үр дүн, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж өгч ажиллав. Мөн 2019 оны хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, түүний ашиглалт, тохижилттой танилцаж, цаашид анхаарах асуудлын талаар сумын удирдлагуудтай санал солилцов.

Аймгийн Засаг дарга 1-р сарын 21-27-ны хооронд УБ хотод томилолтоор ажиллаж жил бүр зохион байгуулдаг аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарын нэгдсэн сургалт, зөвлөгөөнд оролцлоо.

Мөн өнгөрсөн 2019 онд хийж хэрэгжүүлсэн ажил, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын үр дүнгийнхээ талаар салбарын сайд нартаа танилцуулж 2020 оны гэрээгээ байгуулав.

Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, Улсын Онцгой комисс, мэргэжлийн байгууллагуудаас өгсөн үүрэг чиглэл, зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлж ажиллах, мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах үүднээс Ховд аймгийн Онцгой комисс шуурхай хуралдлаа. Хурлын үеэр аймгийн ЭМГ, БОЭТ-ийн удирдлагуудын мэдээллийг сонсож цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, анхаарах асуудлын талаар ярилцан 10 гаруй заалт бүхий шийдвэрийг гаргаж, сан байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 25 өргөдөл бичгээр хүлээн авч, 10 өргөдлийг шийдвэрлэж, 15 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт 6 өргөдөл бичгээр хүлээн авч, 5 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 3 өргөдөл бичгээр хүлээн авч, 1 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 2 сувгаар 33 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 27, биечлэн 6 санал хүсэлт ирүүлснээс гомдол 10, санал хүсэлт 21, шүүмжлэл 1, талархал 1 бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 31 иргэний санал хүсэлтэд хариу өгч, 2 санал хүсэлт шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна. Шийдвэрлэлт 93.9 хувьтай байна. Үүнд халаалтын асуудлаар 11, боловсролын асуудлаар 5, эрүүл мэндийн асуудлаар 4, орчны эрүүл ахуйн асуудлаар 1, хууль эрх зүйн асуудлаар 2, бусад асуудлаар 10 иргэн тус тус хандаж, шийдвэрлэлт 1-10 хоногтой 31, хүлээгдэж байгаа 2 байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг “Саналын хайрцгаар өргөдөл хүлээн авах журам”-ын дагуу энэ сард санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 1111 төвд 1 дүгээр сард санал хүсэлт ирээгүй болно.

Нэг цонхны үйлчилгээ аймгийн ЗДТГ-т байрлаж Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 12 төрлийн үйлчилгээгээр 191 иргэнд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр 1082 иргэнд нийт 5 мэргэжилтэн 27 төрлийн үйлчилгээгээр 1273 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 1 дүгээр сард улсын төсвөөс авах санхүүжилт 5823.8 сая төгрөг ирэхээс 5286,9 сая төгрөг ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орогын шилжүүлгийн 536,9 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.

Сумдад санхүүгийн дэмжлэг 1361,3 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 612,6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт сургууль 2337,2 сая төгрөг, цэцэрлэг 1134,3 сая төгрөг, хүн эмнэлэг 473,4 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 52.1 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 42.1 сая төгрөг тус тус олгосон.

Орон нутгийн 2020 оны төсвийн орлого, зарлага, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн сар, улирлын хуваарийг Сангийн сайдын 2019 оны 299 дүгээр тушаалыг үндэслэн сум, байгууллага, орлогын төрөл, эдийн засгийн ангилалаар фискал програмд шивж баазыг Сангийн яаманд хүргүүлж, аймгийн Засаг даргын 1 дүгээр сарын 17-ны А/13 дугаар захирамжаар 10 хавсралтаар батлан сум, байгууллагуудад 5/111, 133 дугаар албан бичгээр хүргүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан зарлага, санхүүжилт хугацаандаа хийгдэж байна.

Төсвийн ерөнхий нягтлан бодогч Сангийн яамнаас зохион байгуулсан 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан авах талаарх сургалтанд хамрагдаж, байгууллагуудын төсвийн зарлага, санхүүжилтийн тооцоо нийлж, тайланг хүлээн авч байна.

Орон нутгийн төсвийн захирагч, аж ахуйн нэгж байгууллагууд, нягтлан бодогч нарт 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан авах тухай хэлтсийн даргын 5/127 дугаар албан бичгийг хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын 2019 оны жилийн эцсийн санхүүжилтийн тооцоог нийлэн баталгаажуулж холбогдох яамдад хүргүүлэв.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр, авлагыг нэгтгэн гаргаж, Сангийн яаманд хүргүүлэн нийтэд мэдээллээ.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 4156 ширхэг зардлын ваучер бичиж, 9499,7 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн.

Төрийн сангийн нэгжүүдийн 2019 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтын төлөвлөгөөт тайлан, тамга, тэмдгийн бүртгэл, эрсдлийн үнэлгээг нэгтгэж Сангийн яаманд хүргүүлэв.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “SMS” МТ үйлчилгээг шинээр нэвтрүүлж, төсвийн захирагч, нягтлан бодогч нарт мессежээр чиглэл өгч мэдээллийг бүрэн оруулахад анхааруулж ажиллаж байна.

Аж ахуйн нэгж байгууллагын 269 тайлан шивэгдснээс 261 тайланг баталгаажуулсан байна. Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд И-баланс системд цахим хэлбэрээр хүлээн авах, хянан баталгаажуулах, бүртгэлийн алдааг залруулах зэрэг аргазүйгээр ханган ажиллаж байна. Хуулийн хугацаанд нийт 1836 аж ахуйн нэгж байгууллагын тайлан хүлээн авахаас одоогийн байдлаар тайлан хүлээн авалт 14,6%-тай байна.

Мөн шинээр байгуулагдсан 41 аж ахуйн нэгж байгууллагыг цахим системд бүртгэж мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Тайлан өгсөн аж ахуйн нэгж байгууллагуудын тоог татварын хэлтэстэй тулган баталгаажуулсан.

Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болон салбар нэгжийн удирдлагуудтай уулзаж 2019 оны санхүүгийн тайлан баталгаажуулахтай холбогдуулан хамтран ажиллах талаар ярилцаж, хуулийн хугацаанд тайлан мэдээгээ өгч байхыг зөвлөлөө.

Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллийн хувьд аймагт үйл ажиллагаа явуулж буй 9 даатгалын салбар болон даатгалын зуучлагч компанийн салбар, төлөөлөгчийн газар болох Хаан, Хас, Төрийн банкны 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг хүлээн авч нэгтгэн Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх бэлтгэл ажил ханган үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан.

Статистикийн хэлтсээс хүн ам, орон сууцны тооллого явуулах бэлтгэл ажлын сургалтыг 1 дүгээр сарын 4-5-нд амжилттай зохион байгуулж, 97 тоологч, 25 шалгагчийг бэлтгэж, дадлага ажил хийлгэн, кейс ажлуулж дадлагажуулсан.

Хүн ам, орон сууцны тооллогыг 1 дүгээр сарын 9-ний өглөөний 8:00 улс орон даяар зэрэг эхлүүлж, нээлтийг хэлтсийн дарга Д.Даваасамбуу хийж, аймгийн болон Жаргалант сумын удирдлагууд амжилт хүслээ.

Мөн нээлтийн үйл ажиллагаанд ИТХ-ын дарга Г.Пүрэвганди, Засаг даргын орлогч Т.Жаргалсайхан, ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Ч.Багдал, Жаргалант сумын

Засаг дарга Гантөмөр, Жаргалант сумын ЗДТГ-ын дарга Ариунбилэг нар оролцлоо.

Ховд аймгийн хэмжээнд нийт 2325 өрхийн 9903 хүн тооллогонд хамрагдахаар сонгогдож ирснээс 2341 өрхийн 9307 хүнийг тооллогод бүрэн хамруулсан.

Хүн ам, орон сууцны тооллогын хяналтаар 3 ажлын хэсэг гарч, 1-р хэсэгт хэлтсийн мэргэжилтэн Х.Мөнхзолбоогоор ахлуулсан баг Алтай, Үенч, Булган сумдад, 2-р хэсэгт хэлтсийн мэргэжилтэн Т.Анхбаяраар ахлуулсан баг Буянт, Мянгад, Дөргөн сумдад, 3-р хэсэгт хэлтсийн зохион байгуулагч Б.Ууганчимэгээр ахлуулсан баг Манхан, Зэрэг, Цэцэг сумуудад ажиллалаа.

Хяналтын тооллогоор 2325 өрхөөс 235 өрхөд тооллого хийж, 17 сум 91 багт нийт 97 тоологч 25 шалгагч ажиллалаа. Тооллогын материалыг 1 дүгээр сарын 20-24-ний хооронд сумдаас шалган бүрэн хүлээж авлаа.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд:

Хууль, эрх зүйн хэлтэс:

Захиргааны болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 5 шүүх хуралдаанд нэхэмжлэгч болон хариуцагчийг төлөөлж оролцож байна. Шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхээс шаардсан нотлох баримтуудыг нотлох баримтын шаардлага хангуулан хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Хэлтсийн дарга, мэргэжилтнүүд хяналт шинжилгээ, үнэлгээний шалгалтын ажлын хэсэгт багтаж Эрдэнэбүрэн, Дөргөн, Мянгад, Дуут, Манхан, Буянт сумдад ажиллаж сумдын ажлыг дүгнэн тус сумдын эрх зүйн ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хэлтсийн болон мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд санал авч боловсруулж дууссан. Мөн Хууль, эрх зүйн хэлтсийн 2020 оны сургалтын төлөвлөгөөнд аймгийн төвийн 76 байгууллагаас санал авч нэгтгэсэн.

3 өргөдлийг шийдвэрлэж хугацаанд нь хариуг нь өгсөн. 11 иргэнд хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

1 дүгээр сард аймгийн Засаг даргын А захирамж /35/, Б захирамж /1/-ийн хууль зүйн үндэслэлийг хянаж виз өгсөн байна.

Шүүхийн шинжилгээний алба:

1.Монгол Улсын хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн

шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын тушаал, албан даалгавар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2020 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэр, цаашид хэрэгжүүлэх саналыг биелүүлэх зорилт тавьж ажилласан.

Албаны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний албанд хандаж 23 албан бичиг, шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж 197 ирүүлснийг хүлээн авч, бүртгэн цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 25 бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

2019-2020 оны сургалтын хөтөлбөр гаргаж, төлөвлөгөөний дагуу 2 сэдвээр 2 цагийн сургалт зохион байгуулсан.

Эд эсийн шинжилгээг дамжуулж, блокыг дагалдах хуудсын хамт ШШҮХ-нд хүргүүлж хариуг албаны цахим khovd_nifs@yahoo.gov хаягаар авч ажиллаж байна. Албаны сарын хувиарт мэдээ, тайланг гаргаж Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн холбогдох газар, хэлтэс болон аймгийн Засаг даргын Тамгын газарт цаг тухайд нь хүргүүлэв.

2. Гүйцэтгэсэн ажлын талаар

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 16 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 128, эд эсийн шинжилгээт 16, хүний биед хийсэн бусад шинжилгээ 1, тусгай шинжилгээ 35, криминалистикийн шинжилгээ 15 тус тус хийж, дүгнэлт гаргаж, үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүллээ.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 53 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 37 ширхэг мөр, гутлын мөр 21, тээврийн хэрэгслийн мөр 16, бусад ул мөр, эд мөрийн баримт 35-г илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 16, гарын мөр 10 авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийв. Галт зэвсгийн санд сумны хонгио 7, хошуу 5-г авч санд баяжилт хийсэн.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, бүтцийн шинжилгээ, химийн шинжилгээ, биологийн шинжилгээ, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүд болон ирүүлсэн тогтоолуудыг тухай бүрт нь цахим санд оруулан ажиллав.

3. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал

Албаны үйл ажиллагаа, алба хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой мэдээлэл ирээгүй байна. Захиргааны шинжтэй өргөдөл гомдол ирээгүй.

Цагдаагийн газар:

Цагдаагийн газраас энэ оны 1 дүгээр сард иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Улсын хэмжээнд явагдаж буй залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Ятгах тусам нягтал” нэгдсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт салбар төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Ятгах тусам нягтал” аяны хүрээнд аймгийн Прокурорын газар, Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Ятгах тусам нягтал” нэгдсэн арга хэмжээнд нэгдэхийг уриалан орон нутгийн телевизүүд болон “Гэр бүлийн радио 104” зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд сурталчилсан.

Ховд телевизээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар бэлтгэсэн видео контент, залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх видео шторкийг өдөрт 1-2 удаагийн давтамжтайгаар иргэд, олон нийтэд хүргэсэн. Мөн орон нутгийн Ховдын толь сонин, khovdnews.mn сайтад “Ятгах тусам нягтал” арга хэмжээний талаарх аймгийн хэмжээн дэх нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх чиглэлээр ярилцлага, мэдээллийг нийтлүүлсэн.

“Камержуулалт” болзолт уралдааныг эрчимжүүлэх чиглэлээр сум, багийн Засаг дарга нарт албан бичгийг хүргүүлсэн.

Арга хэмжээний хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын 350 ажилтанд “Залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн хууль, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зэрэг сэдвээр сургалтыг зохион байгуулсан. Мөн аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 650 сурагч, 148 аж ахуйн нэгж байгууллагуудад 750 ширхэг зурагт хуудас тараан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга, сургалт мэдээлэл хийсэн.

Замын хяналтаар 1078 зөрчил илрүүлж, бэлэн бус торгуулийн шалгах багажаар 36.950.000 төгрөгийн торгууль оногдуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 31 жолоочийн эрхийг 1 жилийн хугацаагаар хасч шийтгэлийн хуудсаар 1.8000.000 төгрөгийн торгууль оногдуулж, эрхийн үнэмлэхгүй буюу эрх хасагдсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 8 иргэнийг 7-30 хоногийн

хугацаагаар баривчлуулж, тээврийн хэрэгсэл түр саатуулах байранд 41 тээврийн хэрэгслийг түр саатуулсан.

Аймгийн хэмжээнд 2019 оны 12 дугаар сарын 26-наас 2020 оны 01 дүгээр сарын 24-ний байдлаар нийт 269 гомдол мэдээлэл хүлээн авсны 72 буюу 26,7 хувийг гэмт хэргийн шинжтэй, 197 буюу 73,3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна.

Бүртгэгдсэн 59 гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл:

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг-9, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг-5, Хулгайлах гэмт хэрэг-7, Мал хулгайлах-5, Хүчиндэх-3, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох-1, Дээрэмдэх-1, Залилах гэмт хэрэг-8, Эд хөрөнгө устгах, гэмтээх-2, Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг-4 Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах-1, Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах-1, Хууль бусаар ан агнах-3, Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших-1, Хүнийг алах-1, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх-1, Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох-5 тус бүртгэгдсэн байна.

Хүлээн авсан гомдол мэдээллийг төрлөөр нь авч үзвэл: Бусад -146, Бусдын биед халдах-8, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх-12, Залилах-11, Зам тээврийн осол-12, ЗХАБЖЗ-2, Мал хулгайлах-10, ОНАТБА-12, Хулгайлах-8, Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг-14, Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг-1, Хууль сахиулагчийг эсэргүүцэх-3, Хүрээлэн байгаа орчины эсрэг-6, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг-2, Худалдаа үйлчилгээний журам зөрчсөн-5, Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг-6, Дээрэмдэх-2, Гүтгэх-3, Хууль бусаар ан агнах-1, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хангах, завших, тээвэрлэх-2, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг-2, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг-1 гомдол мэдээлэл тус тус хүлээн авсан байна.

Зөрчил гаргасан 148 хүнийг эрүүлжүүлж, зөрчил гаргасан 209 хүнийг 41,025,000 мянган төгрөгөөр торгож, хурд хэтрүүлсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 72 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 42 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулсан болохыг танилцуулъя.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги:

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон ангийн хэвийн үйл ажиллагаа, хоригдол, хоригдогч нарын аюулгүй байдлыг хангах, тэдний дундаас гарч болзошгүй аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хоригдлыг нийгэмшүүлэх ажлын чиглэлээр төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулан, сургалт орж ажиллаж байна.

Тус анги нь нийт 65 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар орон тоо бүрэн ажиллаж байна.

Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилч, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагуудад нэгтгэн жагсааж бүртгэн, ажлын цаг ашиглалтад хяналт тавьж ажиллаж ирсэний зэрэгцээ 7 хоногийн мягмар гарагт тус ангийн нийт бүрэлдэхүүнийг хичээл, сургалт, мэдээлэл хийж, жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаж байна.

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн харуул хамгаалалтыг “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ын дагуу зохион байгуулан ажиллаж байна. Тус ангийн алба хаагчидтай 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох хууль журамд нийцүүлэн баталж, манлайлан ажиллах, ажилдаа хандах хандалагаа дээшлүүлэн ажиллахыг үүрэг болгосон.

Тус ангийн “Ёс зүйн салбар хороо”-ноос Төрийн албаны болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандартыг бүрэн жигд нэг мөр сахин хангуулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд ёс зүйгүй харьцаа, авлига, хүнд суртлын талаар зөрчил гаргасан алба хаагч өнөөдрийн байдлаар гараагүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 07-ний өдрийн А/197 дугаар тушаалаар батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2019-2020 онд зохион байгуулагдах сургалтын хөтөлбөр”-т заасны дагуу алба хаагчдын мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах зорилгоор 2019-2020 онд явуулах сургалтын хөтөлбөр, багшлах бүрэлдэхүүний хуваарийг ангийн даргаар батлуулан сургалтын

төлөвлөгөөний дагуу танхимын болон танхимын бус хэлбэрээр хичээл сургалтыг зохион байгуулж, алба хаагчдыг бүрэн хамруулан ажиллаж байна.

2019-2020 оны хичээл сургалтын үр дүнг өмнөх онтой харьцуулахад алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг нэмэгдсэн байгаа нь танхимын сургалтууд үр дүнтэй зохион байгуулагдсаны нэг хэлбэр бөгөөд ангийн дарга сургалтын явц, ирц, алба хаагчдыг хичээл сургалтын дэвтэрт хичээл бичсэн байдал зэрэгт байнга биечлэн хяналт тавьж, үүрэг чиглэлээр хангаж ажилласан, мөн Ховд их сургуулийн эрх зүйн тэнхимийн хууль зүйн ухааны магистр болон докторын зэрэгтэй багш нар хичээл зааж байгаагийн үр дүн гэж дүгнэж байна.

2020 оны 01 дүгээр сард Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойн баярын хүрээнд Алба хаагчдын чөлөөг цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хичээл сургалтын үр нөлөө, алба хаагчдын багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх үүднээс нөхөрсөг гар бөмбөгийн тэмцээн, Ховд их сургуулийн Эрх зүйн тэнхимийн мэргэжлийн багш нартай хамтран “Хууль бидний амьдралд” сэдэвт АСК тэмцээнүүдийг тус тус зохион байгуулсан.

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үйл ажиллагаа хууль, журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд хоригдол, хоригдогч нарын дундаас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй тайван байгаа болно.

Улсын бүртгэлийн хэлтэс:

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2020 оны 01 дүгээр сард нийт 4359 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас

1. Иргэний бүртгэлийн чиглэлээр-3491

Үүнээс: Аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд-1105 ба шилжин ирсэн иргэд 333 иргэн, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн-772, Гадаад паспорт олголт-267, Иргэний үнэмлэх шинээр олгосон-156 сунгалт-201 дахин олгосон-88,

Иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэл-348 Үүнээс: Төрөлт-176, Үрчлэлт-6, Овог, эцгийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл-10, Эцэг тогтоолт-11, Гэрлэлт-47, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-1, Нас барсны бүртгэл-44, Нөхөн бүртгэл-44, Регистр олголт-3, Иргэний бүртгэлийн лавлагаа олголт-1326, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр-642, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр-199 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажилласан байна.

Мөн иргэдээс нийт 27 өргөдөл, санал хүсэлт ирснээс хуулийн хугацаанд 10 шийдвэрлэж, 7 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлсэн, 10 өргөдлийн хугацаа болоогүй байна.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Эрүүл мэндийн чиглэлээр: 1 сард улирлын чанартай томуу томуу төст өвчний дэгдэлт ихсэж амбулаторын нийт үзлэгийн 15.2 хувийг эзлэх болсон тул Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын яаманд санал хүргүүлэн аймгийн Засаг даргын Захирамжаар сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг түр хааж, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн амралтыг 7 хоногоор сунгах, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагаар ажиллуулж, товллын дархлаажуулалтыг амралтын өдрөөр гэрээр хийх, 0-5 нас, жирэмсэн эмэгтэйчүүд болон архаг хууч өвчтэй хүмүүсийг гэрийн эргэлтэнд шилжүүлэх, холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтан, сургуулийн өмнөх боловсролын арга зүйч, эмч нийт 30 хүнийг хамруулсан “Томуу, томуу төст өвчний үед анги танхимын эрүүл ахуй, халдвар хамгааллын талаар сургалт зохион байгуулах, иргэдэд томуугийн урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлийг хэвлэл мэдээллийн бүх хэрэгслийг ашиглан хүргүүлэх зэрэг бодлогын тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлдсний үр дүнд томуугийн дэгдэлтийг богино хугацаанд цомхотгож чадлаа.

Дэлхийн хэмжээнд цочирдуулаад буй коронавирусын халдвараас сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлэн БНХАУ-ын Хубей мужийн Үхань хотод суралцаж байсан оюутан Улаанбаатар хотоос аймагт 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ирснийг Халдвартын тасагт тусгаарлаж, тархвар судлалын судалгааг авч халдварт өвчин судлалын үндэсний төвийн эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээний нэгжид хүргүүлэн, өвчтөнөөс үүсгэгчийг тодруулах сорьцыг аймгийн вируслогийн лаборатор, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лабораторын шинжилгээнд хүргүүлж шинжилгээгээр корона вирусын халдваргүйг баталгаажууллаа.

Шинээр дэгдээд байгаа коронавирүсийн халдварын үеийн шаардлагатай хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмжийн судалгаа, нөөцийг холбогдох байгууллагуудаар гаргуулан Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүллээ.

Коронавирусын болон томуу, томуу төст өвчний халдвартай холбоотойгоор аймгийн бүх албан газрууд, нийтийн худалдааны газруудаар сурталчилгааны

материалыг тараан ил тод байрлуулж, мэдээллийн бүх хэрэгслээр иргэдэд сурталчлах арга хэмжээг авч ажиллаж байна.

Томуугийн болон шинэ вирусын халдвар дэгдэж байгаатай холбогдуулан сум, өрх, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлгүүдээс 7 хоног бүр томуу, томуу төст өвчний мэдээг авч нэгтгэн халдварт өвчин судлалын үндэсний төвийн томуугийн үндэсний төвд мягмар гараг бүрийн 11 цагт мэдээлж байна.

2020 онд хэвлэл мэдээллийн чиглэлээр хамтран ажиллах орон нутгийн Ховд телевизтэй “Эмч зөвлөж байна” нэвтрүүлэгийг 7 хоногийн лхавга гарагийн 20 цаг 30 минутанд явуулахаар Khovdnews.mn, New khovd.mn, khovdtimes.mn сайтуудтай гэрээлж эхний 1 сард 8 мэдээллийг олон нийтэд мэдээлэх, сурталчилах, газар дээр нь үйл ажиллагаатай танилцаж иргэдэд зөв мэдээлэл хүргэх ажлуудыг зохион байгууллаа.

Тус сард хүүхдийн тусламж үйлчилгээний холбогдох судалгааг гаргуулж, аймгийн хэмжээнд 0-5 хүртэлх насны нийт 12575 хүүхдийн /0-1 насны 2499, 1-5 насны 10076/ суурь эмгэг, өвчлөлтэй 7042 хүүхдийг эмчийн хяналтанд аваад байгаа бөгөөд дутуу төрсний улмаас олон эрхтэний дутагдалтай, эх нялхсын үндэсний төвд эмчлүүлэх шаардлагатай эмзэг амьдралын нөхцөл хангалтгүй нэг өрхийн хотод хүүхдээ эмчлүүлэхэд нь онгоцны зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газраас шийдвэрлэж дэмжлэг үзүүлээ.

Тус сард мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө шийдвэрлүүлэх 17 байгууллага саналаа ирүүлж, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Хүүхдийн оношилгоо эмчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх “Янзага” үүдэн эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 1 жилээр, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх “Эммед партнер 1” эмнэлэг, эд эс судлалын шинжилгээ оношилгоо, зөвлөгөө үзүүлэх “Ач оюун далай” эмнэлгүүдийн үйл ажиллагааг тус бүр 3 жилээр, 1-р зэрэглэлийн эмийн сангийн үйлчилгээ үзүүлэх “Монос Ховд”, 2-р зэрэглэлийн эмийн сангийн үйлчилгээ үзүүлэх “Вансэмбэрүү 2” эмийн сангуудын мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 6 сараар сунгаж, өөрийн үйл ажиллагааны чиглэлээр сүүлийн зургаан сарын дотор үйл тогтмол ажиллагаа явуулаагүй, өмнөх хуралдааны заавар, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй эмэгтэйчүүдийн оношилгоо эмчилгээний “Ач үр”, өөрийн гэсэн ажлын байргүй тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй, тайлан мэдээгээ ирүүлдэггүй тархины

цахилгаан бичлэгийн оношилгоо үзүүлэх “Биндэрьяа”, бичиг баримтын бүрдүүлэлт дутуу, ажлын байргүйгээс ажлын байрны дүгнэлт гаргуулаагүй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй дотрын өвчний оношилгоо эмчилгээ үзүүлэх “Мандах эмч”, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй “Хаш гэрэлт”, захирал нь хот шилжиж үйл ажиллагаа нь зогссон “Сэтэр хүрэн” шүдний эмнэлэг, ажлын байрны дүгнэлт гаргуулаагүй тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх “Эммед партнер 2”, “Скай мед вестерн” эмнэлгүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус цуцалж, төвлөрсөн усан хангамжийн системд холбогдоогүй, халдвар хамгааллын дэглэм хангалтгүй, хүний нөөцийг стандартын дагуу ажиллуулаагүй “Энхрий жаргалан” шүдний эмнэлгийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг 3 сараар түр түтгэлзүүлж, өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлж стандартын шинэ байранд үйл ажиллагаагаа эрхлэх болсон “Булган эмийн эргэлтийн сан”, үйл ажиллагааны байршлаа өөрчилсөн “Монос Ховд эмийн сан, “Энхрий жаргалан” шүдний эмнэлгүүдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын байрны өөрчлөлт хийсэн байна.

Ховд аймгийн 16 сумын эмнэлгийн өвөлжилтийн мэдээг 14 хоног тутам авч нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргэн ажиллаа. Одоогийн байдлаар манай аймагт отроор нүүж яваа иргэд 961, нярай 4, жирэмсэн эх 4, 5 хүртэлх насны хүүхэд 111, 65-с дээш нас 50, архаг, суурь өвчтэй 61, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 12, өөр аймаг, сумын нутагт отор нүүдэл хийж байгаа иргэд 77 байгаагаас нярай 2, жирэмсэн эх 1, 5 хүртэлх насны хүүхэд 16, 65-с дээш нас 4, архаг, суурь өвчтэй 2, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2 байгаа бөгөөд эрүүл мэндийн шаардлагатай дэмжлэг одоогоор авах шаардлагагүй байна.

Тус оны 1 сарын сүүлийн байдлаар яаралтай тусламжийн машины шатахууны нөөц 13 суманд 30-90 хоног, Мөнххайрхан 15 хоног, Чандмань, Мөст суманд 5 хоног, Үенч сум шатахууны өртэй, нөөцгүй, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 16 суманд 30-60 хоног байна. Эх болон 6-24 сартай хүүхдийн олон найрлагат бичил тэжээл болон А витаминь нөөц бүх сумуудад хүрэлцээтэй, сумууд товлотт вакцины 1 сарын нөөцтэй, хадгалалт горимын дагуу явагдаж байна.

Тус сард 2020 онд Эрүүл мэндийн байгууллагуудад хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн тендер зарлаж тендерт нийт 27 байгууллага материалаа ирүүлж, сонгон шалгаруулалт хийж нийт 239,8 сая төгрөгийн үнийн эм, эмнэлгийн

хэрэгслийг тендэрээр нийлүүлж хуваарилалтыг Эрүүл мэндийн газраас сар бүр хийж сумдад хүргүүлж байна. .

Тус сард баруун бүсийн сувилагч нарын зэргийн шалгалтыг Ховд аймагт зохион байгуулж бүсийн 58 сувилагч хамрагдсанаас Ховд аймгаас оролцсон 30 сувилагчийн материал тэнцэж мэргэжлийн зэргээ ахиулах болон шинээр зэрэг авч, эх барихуйн нийгэмлэг дээр зохион байгуулагдсан зэргийн шалгалтанд 3 эх баригчийн материалыг хүргүүлсний 2 эх баригч ахлах, 1 эх баригч тэргүүлэх зэрэг хамгаалсан байна.

Энэ оны эхний 1 сарын байдлаар салбарын 25 байгууллагуудын 2020 оны төсвийн сарын хуваарийн саналыг Эрүүл мэндийн яам, аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж, батлагдаж ирсэн санхүүжилтийн дүнд багтаан хуваарилж санхүү төрийн сангийн мэргэжилтнээр хянуулан баталгаажуулж, сум, өрхүүдэд хүргүүлснээр сум, өрхийн эрүүл мэндийн төв санхүүжилтээ бүрэн авах боломж бүрдлээ.

Тус сард салбарын 24 байгууллагуудын 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлж, 2019 онд хийсэн үйл ажиллагаатай танилцан, ололт, амжилт, алдаа дутагдал, тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэн, цаашид анхаарах асуудлын талаар холбогдох дарга, мэргэжилтнүүдэд чиглэл өглөө.

Мөн эрүүл мэндийн байгууллагууд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, өндөр өртөгтэй тоног төхөөрөмж, зайлшгүй солих шаардлагатай сэлбэг хэрэгслийн жагсаалтыг эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө төлөвлөлтийн системийн /heps.hdc.gov.mn/-д сайтад шинээр шивж орууллаа.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад medee.1212.mn сайтад мэдээ, тайланг хугацаа хоцроохгүй, чанартай, бодитой, зөв ирүүлэх талаар албан тоот хүргүүлсний үр дүнд программд бүртгэлтэй 66 байгууллагаас 50 аж ахуй нэгж байгууллага тайлангаа илгээж хамрагдалт 75,7 хувьд хүрч программд ороогүй болон хамааралгүй байгууллагуудыг жагсаалтаар гаргаж нэмэх, хасах эсэх саналыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд шийдвэрлүүлэхээр хүргүүллээ.

Боловсрол, Соёл урлагийн чиглэлээр: 2020 оны 1 дүгээр сард 31 ажлыг төлөвлөн ажилласнаас 31 ажил бүрэн хэрэгжиж, 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

1.Олон улсын эко сургууль хөтөлбөрийн сүлжээний өргөмжлөл бүхий Тогтвортой хөгжлийг дэмжигч эко сургуулиудын багш, болон удирдах ажилтанд зориулсан Ахисан шатны” 2 дахь сургалт Сэлэнгэ аймгийн Зүүн хараа Мандал 4-р сургууль

дээр амжилттай явагдаж Ховд аймгийн Жаргалант сумын 7, 1 дүгээр сургуулийн 2 удирдлага 7 багш хамрагдлаа.

2.Буянт, НТБТ, 3, 7 дугаар сургуулийн багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах арга зүй сургалт зохион байгуулсан. Сургалтад 35 багш хамрагдлаа. Сургалтыг орон нутгийн болон үндэсний ментор багш нар зохион байгуулсан нь үр дүнтэй байлаа.

3.“Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төсөлтэй хамтран бага ангийн багш нарт “Дохионы хэл”-ний сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулсан. Сургалтад 24 сургуулийн 24 бага ангийн багш хамрагдлаа. Сургалтыг сонсголгүйн боловсрол төвийн багш Ганхуяг зохион байгуулж, сургалтад хамрагдсан багш нарт дохионы хэлний гарын авлага, CD хичээл, цагаан толгой, тоолж нэрлэж сурах үзүүлэн сургууль бүрт өгсөн нь үр дүнтэй байлаа.

4.Бага ангийн сургалтын менежерүүд Говь-Алтай, Өвөрхангай, Улаанбаатар хотын 38, 40, 21 дүгээр сургуулийн туршлага судалж, БМДИ-с бага ангийн хүн байгаль, монгол хэлний хичээл заахад анхаарах асуудал, бага боловсролын чанарын шинэчлэлийг дэмжих төвийн тэргүүн Г.Батболд багшаас үнэлгээний даалгавар боловсруулах блюпринт хэрхэн боловсруулах, даалгаврын ялгах чадварыг хэрхэн тодорхойлох, хүнд хөнгөний зэргийг хэрхэн олж даалгавраа шинжлэн туршиж найдвартай даалгавар боловсруулах, даалгаварт шинжилгээ хийх арга зүйд суралцлаа. Сургалтын менежерүүд ажлын байран дээрээ багш нараа чадавхжуулах, сургалтын орчин, арга зүйгээ сайжруулахад шинэ санаа олныг харж хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

5. 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Жаргалант сумын 3 дугаар сургуулийн багш нарын хүсэлтээр “Гар утас ашиглан үр дүнгийн үнэлгээ хийх арга зүй” сургалтыг зохион байгуулж, 21 багш хамрагдаж шалгалтын хариултын хуудсыг гар утас ашиглан боловсруулах, боловсруулсан хариултын хуудсаар шалгалт авах, түүнийг гар утас ашиглан уншуулах зэрэг онол дадлага хослуулсан сургалтыг зохион байгууллаа.

6. Мэргэжил сонголт сургалтыг зохион байгуулж ЕБС -ын 30 багш оролцлоо. Боловсролын магдалан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс 2020 оны 01 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд Ховд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 12 ангийн төгсөгчид, сургуулийн захирал, сургалтын менежер, заах аргын нэгдлийн ахлагчид,

анги удирдсан багш нар Боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутаг дахь боловсролын салбарын хэтийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх, магадлан итгэмжлэгдсэн их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг таниулах зорилгоор “Боловсролын чанар- хөгжил” сэдэвт сургалтыг БМИҮЗ-ийн ажлын албаны захирал Ж.Ариунболд, ахлах мэргэжилтэн Б.Оюунцэцэг, мэргэжилтэн Г.Даваажаргал нар зохион байгуулан явуулж, 12-р ангийн 300 төгсөгчид, сургуулийн захирал, сургалтын менежер, заах аргын нэгдлийн ахлагчид, анги удирдсан багш нар нийт 72 багш удирдлага хамрагдлаа.

Жаргалант сумын 4 дүгээр ангийн сурагчдын дунд математик, монгол хэлний хичээлийн нэгдмэл агуулгаар сурлагын амжилтын судалгааг 1 дүгээр сарын 29, 30 нд авахаар бэлтгэл хангаж, судалгаанд 60 бүлгийн 1680 сурагч хамрагдахаар хамруулна.

Хими биологийн хичээлээр 10 дугаар ангийн сурагчдаас хөндлөнгийн үнэлгээ хийх шалгалтын материал хүргүүллээ.

Хими сорил-2-ыг зохион байгууллаа .Сорилд нийт 120 гаруй сурагч хамрагдлаа.

Аймгийн Боловсрол Соёл урлагийн газрын мэргэжилтэн, Жаргалант сумын 16 цэцэрлэгийн арга зүйчидтэй хамтран нийт 5 ажлын хэсгийн гишүүд 2020 оны 01 дүгээр сарын 06-08 ны өдрүүдэд төрийн болон төрийн бус өмчийн 27 цэцэрлэгт хяналт, үнэлгээ зөвлөн туслах ажил хийлээ.

Зөвлөн туслах ажилд Жаргалант сумын төрийн болон төрийн бус өмчийн 32 багшийн хичээлд сууж, зөвлөгөө өгөхөөс гадна, 27 цэцэрлэгийн орчны стандартын үнэлгээг хийлээ.

Сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн 15 цэцэрлэгийн үйл ажиллагааны орчны стандартын үнэлгээ өмнөх оны мөн үеэс 2 хувиар ахисан үзүүлэлттэй байгаа нь жил бүр хөндлөнгийн үнэлгээ хийсний үр дүн харагдаж байна. Түүнчлэн 32 багшийн 510 хүүхдийн хичээлд сууж, ажиглалт тэмдэглэл хийж, зөвлөгөө өгч ажиллахаас гадна төрийн бус өмчийн 12 цэцэрлэгийн багш нарт мэргэжил арга зүйн дэмжлэг өгч ажиллаа.

Япон улсад Боловсрол соёл урлагын газрын дарга, математик хариуцсан мэргэжилтэн нар суралцах аялал, сургалтанд хамрагдаж, Япон улсын туршлага, ололт амжилт, арга зүйн зарим санаа, цаашид орон нутагт хэрэгжүүлж болох үзэл санааг түгээх зорилгоор боловсролын газрын мэргэжилтнүүдэд танилцуулга мэдээлэл хийлээ.

МУБИС-ийн төслийн зөвлөх багаас Ховд аймгийн төслийн 6 багийн гишүүдийн боловсруулсан видео хичээлд өгсөн аймгийн багийн ахлагч нарт танилцуулж, зөвлөмж мэдээллийг хүргүүлээ.

Тус зөвлөмж мэдээллийн хүрээнд 2020 оны 1 дүгээр сард багтаан видео хичээлийн зохиолыг шинэчлэх, найруулагчийн төлөвлөгөөг сайжруулах хугацаатай үүргийг өгөөд байна.

2020 оны 1 дүгээр сарын 07-ны өдөр БСУГ-ын мэргэжилтний зөвлөлөөр Математик, физикийн зарим багш нар болон сургуулийн сургалтын чанарыг хэлэлцлээ. Математик, Физикийн хичээлийн сургалтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд хичээлийн жилийн 1 дүгээр улиралд авсан хөндлөнгийн шалгалтаар хангалтгүй дүн үзүүлсэн дээрх сургуулиудад тодорхой үүрэг чиглэл өгч биелэлтийг авч хэлэлцсэн. Уг үүрэг чиглэлийн биелэлтийг тодорхой түвшинд хяналтандаа авч ажилласан Манхан, Буянт сумын сургууль, хангалтгүй байгаа Мянгад, тухайн хугацаанд ирж тайлангаа хэлэлцүүлж, танилцуулаагүй Эрдэнэбүрэн сумын сургуулиудад анхааруулга өгч дахин тайлагнахыг үүрэг болголоо. Асуудлыг мэргэжилтний зөвлөлөөр авч хэлэлцэж байгаа нь анхны тохиолдол бөгөөд нилээд үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Жаргалант сумын ЕБСургуулиуд, Насан туршийн боловсрол төв, Ховд Их сургуулийн дэргэдэх Лицей ахлах сургууль дээр Боловсрол соёл урлагийн дарга, дэд дарга мэргэжилтнүүд багш нарын хичээлд ажиглалт хийх, мэргэжлийн зөвлөгөө өгөх, багш, сурагчидтай уулзах, Сорил, судалгаа хийх зорилготойгоор 2020 оны 1 дүгээр сарын 23-28-ныг дуустал ажиллаж байна.

Боловсрол соёл урлагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлэлцэж, мэргэжилтнүүд 2020 оны төлөвлөгөөг батлууллаа.

Жаргалант сумын тамгын газарт БСУГ-ын мэдээлэл, Ховд хотын түүхт 335 жилийн ойг угтсан 5 ажлын саналыг тус тус хүргүүлээ.

Сургуулийн 38, цэцэрлэгийн 11 илтгэл уншиж, 2 дахь шатанд оролцох илтгэлийг шалгаруулав.

Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгүүдэд ажиллаж байгаа туслах багшийн хэрэгцээний судалгааг БСШУСЯ-наас ирүүлсэн маягтын дагуу цэцэрлэгүүдээс авч, нэгтгэн, 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хүргүүлээ.

ЕБС, сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлэх зөвлөмжийг бүх сургууль, цэцэрлэгийн багш нарт хүргүүлээ.

Сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгчдийн сонгон шалгаруулалт зохион байгуулж, нийт 9 багш шалгалтанд орсноос Мөнххайрхан сумын сургуулийн захирал Батзаяа, Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэгийн эрхлэгч А.Өлзийбаяр нар шалгалтандаа тэнцлээ.

Сургууль, цэцэрлэгүүдийн 2020 оны сар улирлын хуваарийг баталгааж, Дуут, Манхан Буянт сумдын байгууллагуудын үйл ажиллагаа, төсөв, үр ашиг, хөрөнгө оруулалтын талаар үнэлгээ хийж ажиллаа.

Соёл урлаг, спортын чиглэлээр:

Соёл урлаг, спортын салбар 2020 оны 01 дүгээр сард байгууллагын үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг гарган ажиллалаа.

Аймгийн Музей нь ИТХ-ын хөрөнгө оруулалтаар 1990 онд Ховд аймгаас Ардын их хурлын депутатаар сонгогдон ажиллаж байсан 18 хүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор тус байгууллын алдарын танхимд депутатын булан байгуулан 2020 оны 01 дүгээр сарын 13-ний өдөр нээлтээ хийж, 30 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо.

Төрийн Шагналт Ардын Жүжигчин Ж.Чулууны нэрэмжит Алтангадас одонт Хөгжимт Драммын Театр нь 2020 оны 01 дүгээр сарын байдлаар байгууллагын төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээ, дотоод журмыг шинэчлэн батлаж уран бүтээлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Ганданпунцагчойлон хийдтэй хамтран зохион байгуулдаг “Шашин урлагийн цэнгүүн” , МҮОНРТ-тэй хамтран сар шинийн баярт зориулсан теле зохиомжит нэвтрүүлэгт орох зэрэг уран бүтээлүүдийн бэлтгэл ажилд ороод байна.

Нийтийн номын сан нь 2020 оны 1 дүгээр сараас эхлэн Номын тооллого хийж байна. Өнөөдрийн байдлаар 12600 ширхэг ном тоолж данс бүртгэлд бүртгэн ажиллаж байна

2020 оны 01 дүгээр сард 630 гаруй иргэдэд соёл урлагийн үйлчилгээ үзүүллээ.

Биеийн тамир спортын газарт Монголын байт сурын холбооны төлөөлөгч Ховд аймагт ажиллан байт сурын холбоо байгуулан, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

Мөн Мөнгөлөг шөгшуурга цас мөсний баяр болон спортын 2 төрлөөр аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан байсан хэдий ч ханиад томууний дэгдэлт, корона вирусын хөл хорио гарч олон

нийтийг хамарсан арга хэмжээг хориглосон тул Соёл урлаг, спортын салбарын томоохон арга хэмжээнүүдийг тодорхойгүй хугацаагаар хойшлууллаа.

Хөдөлмөр нийгмийн хамгаалалын чиглэлээр:

Зургаа: Сумдын мэдээлэл:

Алтай сум: Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний 2019 оны тайланг Дотоод ажил хариуцсан, хууль эрх зүйн мэргэжилтэн Т.Хатанбаатар албан хаагчийн мэдээллийг программд бүрэн шивж орууллаа.

Шинэ үндсэн хуулийн ойн баярыг угтаж 2020 оны 01 сарын 09, 10 ны өдрүүдэд Хавтаг, хилийн зурвас газар болох Тахийн шар нурууны чиглэлд өвөлжиж буй 100 гаруй малчид, хилийн 6,7 дугаар зиставуудад “Захчин түмний буян заяа” төрийн бус байгууллага сумын хурлын байгууллагатай хамтарч урлаг соёлоор үйлчилж шоу үдэшлэг зохион байгуулалаа.

Шинэ үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойд зориулан үндэсний бөхийн тойргийн барилдаан, Шатрын тэмцээн, 100 буудалт даам, шатар, зохион байгуулж, Алтангадас багийн сумын аварга малчин Б.Загдбазар, Бодонч багийн сумын аварга малчин Ц.Эрдэнэ-Очир нар ивээн тэтгэлээ.

Монгол улсын гавъяат тамирчин, Ази тивийн залуучуудын аварга, Монгол улсын өсөх идэр начин Адуучийн Баатархүү агсны мэндэлсний 63 жилийн ойд зориулсан хүчит бөхийн барилдаан 01-р сарын26-ны өдөр зохион байгуулагдаж Тахилт багийн иргэн Д.Баттогтох уран барилдааны шагнал дааж, ахмад С/З С.Ганцэрэгийн гэр бүл ивээн тэтгэж зохион байгууллаа.

Алтай нутгийн зон олныхоо анхааралд: шинэ Коронавирусын халдвар хил залгаа улс оронд гарч Монгол улсын Засгийн газраас шийдвэр гарсантай холбогдуулан хил залгаа Хятад улс руу зорчихгүй байх, нүүрс тээврийн жолооч нар тээвэр хийхгүй байхыг анхааруулав.

01 дүгээр сарын 25-ны өдөр Алтайчууд “Эрүүл агаар эм ” сэдэвт цас мөсний баярыг амжилттай сайхан тэмдэгллээ. Энэ өдрийн цас мөсний баяраар мөсөн шагайн харваа, цасны сумо, тэшүүр, олс таталт, гүйлтийн тэмцээн, зэрэг тэмцээнүүдийг эрэгтэй, эмэгтэй төрлөөр мөн хүүхдүүдийн Дээлтэй монгол тэмцээнийг шалгаруулж агаарт өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ.

ХАА-н ажилтан Т.Өнөржаргал 2020 онд арьс ширний урамшуулал авах 134 өрхийн падан программд шивж холбогдох газарт явууллаа.

Булган сум: Сумын удирдах ажилтнуудын хуралдааныг зохион байгуулж хийсэн ажлын тайлан, цаашил хийх ажлын мэдээлэл солилцож сарын төлөвлөгөөгөө боловсруулан ажиллаа.

Монгол Улсын шинэ үндсэн хуулийн өдрийг тохиолдуудан сумын төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтанд нийт 250 гаруй төрийн албан хаагчид хамрагдсан. Түүнчлэн шинэ үндсэн хууль батлагдсан 28 дахь өдрийг тохиолдуулан үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулсан бөхийн барилдаанд нийт 128 бөх барилдсанаас сумын заан Б.Ганзориг түрүүлж, залуу бөх П.Бат-Амгалан үзүүрлэсэн байна.

Булган суманд нийт 800 гаруй төрийн албан хаагчид иргэдэд төрийн үйлчилгээг хүргэдэг бөгөөд төрийн албан хаагчдийн дунд сургалт, урлаг, спортын тэмцээнийг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 13 төрийн байгууллага оролцсоноос нийлбэр оноогоороо Минжит Булган цогцолбор сургууль 1 дүгээр байр, 1 дүгээр 12 жилийн сургууль 2 дугаар байр, 2 дугаар цэцэрлэг 3 дугаар байр эзлэж “Шилдэг төрийн байгууллага”-аар шалгарсан.

Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын хэмжээнд эзэнгүй золбин нохой устгах арга хэмжээг авч ажиллаа. Үүний хүрээнд 90 нохой устгаж хогын цэгт хүргэлээ. Мөн сургууль цэцэрлэгтээ холоос явдаг хүүхдүүдийн нийгмийн асуудал шийдэх зорилгоор Монгол үйлдвэрлэсэн “Мон Эко” автобусаар сургуулийн сурагчдад үйлчилхээр бэлтгэл ажил хангаад байна.

Аймгийн Засаг даргын орлогч Жаргалсайханаар ахлуулсан ажлын хэсэг тус суманд ажиллаж усны халиа давсан малчин айл өрхүүдийн аж байдалтай танилцлаа. Мөн 2019 онд Ховд аймаг хийсэн ажлын талаар төрийн албан хаагч, иргэдэд мэдээлэл хийсэн.

Буянт сум:

Тус суманд 1 дүгээр сарын 09-16-ны өдрийн хооронд хүн ам, орон сууцны тооллого явагдлаа. Тус тооллогыг Норжинхайрхан багт Б.Эрдэнэцогт, Амарзаяа, Нарийн гол багт Б.Хишигзаяа, Э.Мягмар, Наранхайрхан багт Ш.Батсайхан, Б.Алтаншүр, Цагаан-эрэг багт М.Кистаувай, Б.Гэрэлчулуун, Цагаан бургас багт Б.Аюурзана, Б.Даариймаа нар зохион байгуулан явууллаа.

1 дүгээр сарын 13-ны өдөр Шинэ үндсэн хууль батлагдсаны өдөрт зориулан дараах уралдаан тэмцээнийг зохион байгууллаа.

- 2019 онд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар Ж.Бумбат, Нийгмийн даатгалын хуулийн зарим өөрчлөлтийн талаар Б.Хишигзаяа,

Татварын хуулийн өөрчлөлтийн талаар Б.Ижилзаяа нар сургалт зохион байгууллаа. Тус сургалтад 120 төрийн албан хаагч хамрагдаж холбогдох хуулийн талаар мэдээлэл авсан.

- Төрийн албан хаагчдын дунд Үндсэн хууль болон танин мэдэхүйн асуултаар “Элсэн цаг” тэмцээн зохион байгуулж тус тэмцээн 6 баг оролцож сумын Эрүүл мэндийн төвийн баг 1-р байр, сургуулийн баг 2-р байр эзэлсэн.

- Асуулт хариулт танин мэдэхүйн АХА тэмцээнийг мөн Үндсэн хууль болон танин мэдэхүйн сэдвээр явуулсан тус тэмцээнд Б.Жаргалсайхан түрүүлж, Т.Энх туяа удаах байранд орлоо.

- Гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж тус тэмцээнд 7 баг оролцож 1-р байрт сургуулийн баг, 2-р байрт ИТХ-ын баг тус тус эзэлсэн амжилт үзүүллээ.

2020 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр тус суманд аймгийн цагдаагийн газрын албан хаагчид ирж 2019 оны цагдаагийн газрын хийж хэрэгжүүлсэн ажлын талаар тайлан болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээ таниулга хийлээ. Тус үйл ажиллагаанд Норжинхайрхан багийн ард иргэд болон төрийн албан хаагчид нийт 50 гаруй хүн хамрагдаж малын хулгайн гэмт хэргийн илрүүлэлт болон, бусад хэрэг зөрчлийн талаар мэдээлэл авсан.

Мөн энэ үеэр цагдаагийн газрын албан хаагчид ард иргэдэд ая дууны мэндчилгээ дэвшүүлэн, ард иргэдийн дунд “АХА” тэмцээн зохион байгуулагдлаа.

1 дүгээр сарын 18-ны өдөр тус суманд Аймгийн Засаг Даргын Тамгын газраас 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирж Хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажиллалаа.

Коронавирусын халдвараас сэргийлж сургууль, цэцэрлэгийн амралт 3 дугаар сарын 02 өдөр хүртэл хойшлоод байна.

Сумын эрүүл мэндийн төвөөс Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар амны хаалтыг тогтмол зүүж хэвших мөн олон нийтийн үйл ажиллагаанд оролцохгүй байх талаар анхааруулж байна.

Тус сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Дөргөн сум:

Засаг даргын тамгын газар: Төрийн удирдлагын чиглэлээр :

Монгол улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, хуулийн агуулга, ач холбогдол, түүнд орсон нэмэлт,

өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг танилцуулах зорилгоор “Монгол улсын шинэ үндсэн хуулийг сурталчлах өдөр”-ийг 01 сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Уг өдрөөр албан байгууллагууд Үндсэн хуулийн бүлэг тус бүрийг хариуцан авч, ард иргэдэд мэдээлэл өгч, хуулийг таниулан сурталчлан, сонирхсон асуултанд хариулт өглөө. Мөн ард иргэдийн дунд шагайн харваа, бүжгийн тэмцээнийг зохион байгууллаа.

Байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх Аймгийн ИТХ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг 01 сарын 18, 19-ны өдрүүдэд суманд ажилласан. Хяналт шалгалтаар Засгийн газрын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөр, засгийн газрын болон аймаг, сумын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны үндсэн чиглэл, аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга байгуулсан гэрээ, аймгийн сумын ИТХ-ын тогтоол шийдвэр, байлгууллагуудын хөгжлийн стратеги, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт, ёс зүйн хорооны ажил, сум хөгжүүлэх болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, зээл эргэн төлөлт зэрэг ажлуудын биелэлт, үр дүнтэй нь танилцаж, үнэлэлт, дүгнэлт өгсөн.

Хөдөөгийн багуудын айл өрхүүдийн өвөлжилтийн байдалтай танилцах, санал хүсэлтийн сонсох, төр засгийн бодлого шийдвэр, хууль тогтоомж, цаг үеийн мэдээлэл өгөх, эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх зорилгоор Аргалант, Агваш, Сээрийн чиглэлд ажлын хэсгүүд хуваагдан гарч, малчдын эргэлтийг 01 сарын 24-26 –ны өдрүүдэд зохион байгууллаа. Аргалант багт Сумын Засаг дарга Т.Заяа, багийн эмч М.Орломсүрэн, нийгмийн даатгалын байцаагч Д.Алтансоёмбо, татварын байцаагч Б.Төмөрцоож нар нийт 39 айл өрх, Агваш баг болон Сээр багийн гол зэгс, нууранд өвөлжиж байгаа нийт 43 айл өрхөөр ИТХ-ын дарга Н.Базаррагчаа, багийн Засаг дарга Н.Пүрэвхуяг, багийн эмч О.Цэцэгсүрэн, Иргэний улсын бүртгэгч М.Цэвээнсүрэн, Байгаль орчны байцаагч Т.Ням, Сээр багийн ууланд өвөлжиж байгаа 20 айл өрхөөр Сээр багийн Засаг дарга С.Нямхүү, багийн эмч Э.Даваажаргал, ХАА-н мэргэжилтэн Л.Содномцэрэн нар тус тус эргэлт хийллээ. Эргэлтээр явахад малчид өвөлжилт өнтэй сайхан байна гэсэн халуун дулаан үг хэлж, энэ жилийн эхний төлөө төлүүлсэн байсан.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Тэтгэврийн даатгалын сангаас 390 тэтгэвэр авагчдад 125800,6 мянган төгрөгийн санхүүжилтаар тэтгэврийг бүрэн тавьж олгосон. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 284, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч-32, тахир дутуугийн тэтгэвэр

авагч-74 байна. Сайн дурын даатгалд нийтдээ 27 даатгуулагчийн 1925,1 мянган төгрөг, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 15146,4 мянган төгрөгийн шимтгэлийн орлого тус тус төвлөрүүлсэн. Энэ сард шинээр 3 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгуулж ажилласан. Эрүүл мэндийн даатгалд 30 даатгуулагчийн 977,0 мянган төгрөгийн орлого оруулсан.Тэтгэмжийн даатгалын сангаас 1 даатгуулагчдад хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжид 50,3 мян төг, 1 хүнд оршуулгын тэтгэмжид 1000,0 сая төг тус тус олгосон.

Газрын чиглэлээр:

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Газар өмчлөл, эзэмшлийн гэрчилгээтэй иргэдийн газрын төлбөр болон татварын талаарх мэдээллийг цахимжууллаа. Цахимд 210 гэрчилгээний мэдээлэл шивсэн. Ингэсэнээр иргэдийн газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээлэл бүрэн харах боломжтой боллоо. Лэнд менежер прагроммд идэвхигүй 50 гаруй нэгж талбарыг идэвхижүүлэн, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Аймгийн аварга малчин шалгаруулах болзлын дагуу 5 малчны материалыг бүрдүүлэн аймгийн ХХАА-н газарт хүргэж ажиллаа. Засгийн газрын 2015 оны 122–р тогтоолын дагуу арьс, шир бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин болон мал бүхий этгээдийн хобогдох баримт материалыг нь бүрдүүлж хүлээлгэн өглөө. Үүнд сумын дүнгээр 160 падаанаар бүгд 2928 ширхэг арьс, шир адууны 24, үхэр 287, ямаа 1344, хонь 1273 тушаасан байна.

Мал эмнэлэгийн чиглэлээр:

Мал амьтны халдварт, халдваргүй өвчин, шимэгчтэх өвчин, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мал амьтан, түүхий эд бүтээгдэхүүн, малын тэжээлийн үзлэг шинжилгээний талаар мэдээллийг аймгийн мал эмнэлэгийн газарт хугацаанд нь гаргаж, хүргүүлсэн. Дөргөн сумын 2020 онд шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, Агваш арал МЭҮН, Алтайн шилмэл сүрэг МЭҮН-ийн 2021 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакцины захилга зэргийг гаргаж, батлуулан аймгийн МЭ-ийн газарт хүргүүлсэн.

2018, 2019 оны малын вакцинжуулалтыг цахим системд шивж оруулсан.

Татварын чиглэлээр:

2019 оны хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн материалыг 01 сарын 08-ны өдрөөс 31-ныг хүртэл хүлээн авахаар ажиллаж байна.

Одоогоор 14 хүний материалыг хүлээн авч, тайланг нь гаргаад байна. 2019 оны 04 дүгээр улирлын тайлан буюу жилийн эцсийн санхүү татварын тайланг аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудаас гаргуулан 02 сарын 10-ны дотор хугацаанд явуулахаар ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв :

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Амбулатороор 365 хүн үйлчлүүлсэн байна. Нийт дуудлага-15 үүнээс том хүн 10, хүүхэд 5, Хэвтэн эмчлүүлсэн 27, Өдрийн эмчилгээнд 15 , гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээнд 30, сэргээн засах эмчилгээнд 10, оношилгоо шинжилгээнд 60 хүн хамруулан тайлан мэдээг цаг тухайд өгч ажиллаж байна.

Эх хүүхдийн ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэ сард шинээр 8 эхийг хяналтанд оруулж, нийт 46 эхийг жирэмсний хяналтанд авч ажилласан. 2 эх төрсөн .

01 сард оношлогоо шинжилгээ буюу элэгний В, С вирусд 25, хеликобактерт 39, сахарт 20, шээсний шинжилгээнд 25, цусны бүлэгт 25 тус тус хамрагдсан. Дархлаажуулалтанд 49 хүүхэд хамрагдсан.

Ерөнхий боловсролын сургууль: Багш нараа хөгжүүлэх чиглэлээр:

2020 оны 1-р сарын 5-наас 12 хүртэл бага боловсролын сургалтын менежерүүд Говь-Алтай аймаг, Өвөрхангай аймаг, Улаанбаатар хотын сургуулиудын туршлага судлах, харилцан солилцох болон БМДИ-д бага боловсролын шинэчлэлийг дэмжих төвийн сургалтанд бага ангийн сургалтын менежер О.Ган-Эрдэнэ хамрагдлаа. Ховд аймгийн хэмжээнд нийт 24 бага ангийн сургалтын менежерүүд , мэргэжилтэн Э.Бат-Эрдэнэтэй хамт Говь-Алтай аймгийн 1-р сургууль, 4-р сургууль, Өвөрхангай аймгийн “Мэргэд” сургууль, Улаанбаатар хотын 38,40,21-р сургууль мөн “Шавь” цогцолбор сургуулийн туршлагаудтай танилцлаа. Мөн Хүн байгаль, Монгол хэл, Блюпринт боловсруулах сургалтанд 2 хоног хамрагдлаа. Энэхүү сургалт, туршлагаа сургуулийн нийт багш нарт танилцуулж шинэ шинэлэг санаануудыг хуваалцлаа.

Хичээлийн хуваарийг дэлгэрэнгүй ойлгомжтой хийх зорилгоо бага ангийн 11 багш, 6 настны багш, НТБ-ын багш Л.Нарангэрэл гэсэн нийт 13 багшид “Блюпринт боловсруулах арга зүй” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Ховд аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан хөгжлийн бэрхшээлтэй сурагчтай харилцах дохионы хэлний сургалтанд бага ангийн багш Ц.Цэцэгсүрэн хамрагдаж бүх багш нартаа сургалт явууллаа.

Сурагчдаа хөгжүүлэх чиглэлээр:

Бага ангийн багш С.Цэнгэл, Ч.Бадмаа, 6-н настны багш Б.Цэнд-Аюуш нар Дэлхийн зөн олон улсын байгууллагаас зохион байгуулсан “Оролцоод хөгжье” сургалтанд хамрагдлаа. Энэхүү сургалтаа бага ангийн нийт 286 сурагчдын дунд зохион байгуулж “Оролцоод хөгжье” бага ангийн сурагчдын клубыг байгууллаа.

7-р сургуулиас зохион байгуулж буй Математик, Монгол хэл, “Нэгдмэл агуулга”-ын 4-р ангийн үр дүнгийн судалгаа, 3-р ангийн дуу хөгжмийн үр дүнгийн судалгааг амжилттай зохион байгуулж анализыг БСУГ-т хүргүүлэв.

Бага ангийн заах аргын нэгдлээс “Дэвтэр бол сурагчийн толь мөн” 1 сарын аянг бага ангийн нийт сурагчдын дунд 1 сарын 20-иос 2 сарын 20 хүртэл зарлан явуулж байна.

Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн эмч С.Нууцчимэг бага ангийн багш нартаа хамтран 01 дүгээр сарын 23-ны өдөр 1-5 дугаар ангийн нийт 285 сурагчдад анги бүрээр орж “Томуу томуу төст өвчний” талаар мэдээлэл, сургалт хийж гарын авлага тараалаа.

Бусад ажлын талаар:

01 дүгээр сарын 06-09-нийг хүртэл 2019 онд сургуулийн сургалтын орчинг дэмжих чиглэлээр орж ирсэн хөрөнгийг нярав Д.Жаргал, Ч.Баттогтох нар хамтран жагсаалтыг гаргаж баталгаажуулан сумын ИТХ-д хүргүүлэв.

Сурагчдын аюулгүй байдал, тав тухтай дулаан орчныг бүрдүүлэх зорилгоор бага болон дунд сургуулийн дулааны шугам дээр гарсан гэмтлийг 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр слесарь, багш, ажилчид хамтран засварлав. Нийт багш, ажилчдын хурлаар гарсан шийдвэрийн дагуу үзвэр үйлчилгээ үзэхдээ бусадтай эелдэг харьцах, соёлтой байх, хандлагаа өөрчлөх зорилгоор хамтран ажиллах “Хандлагаа өөрчилье” уриалгыг албан байгууллагуудад албажуулан хүргүүлэв.

Дөргөн сумын ерөнхий боловсролын сургууль, Увс аймгийн Наранбулаг сумын ерөнхий боловсролын сургуулиуд хоорондоо нөхөрсөг уулзалт хийж харилцан туршлага солилцлоо.

Соёлын төв:

2019 онд хийсэн ажил, ирсэн явсан бичиг, тушаалуудыг үдэж, архивлав. Уламжлал болгон явуулдаг арга хэмжээ болох сар бүрийн 05-ны өдөр бүжиглэх

өдөр, 10-ны өдөр дуулах өдрийг тус тус зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 30 гаруй иргэд оролцож, бүжиг, дуу сурлаа.2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичигээ хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнүүдээ боловсруулж батлууллаа.

Жаргалант сум:

Төрийн байгуулалтын чиглэлээр:

Ховд аймгийн Жаргалант сумын багуудын ИНХ-ыг 2020 оны 01 дүгээр сарын 21-27-ны өдрүүдэд зохион байгуулж байгаа бөгөөд Алагтолгой, Бугат, Цамбагарав, Бичигт, Буянт багуудын ИНХ-ыг 2020 оны 01 дүгээр сарын 21, 22, 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулж 2019 оны Жаргалант сумын хэмжээнд хийж хийгдсэн ажлын талаар мэдээлэл хийж Багийн Засаг даргынхаа үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэнд үнэлэлт өгч 2020 оны төлөвлөгөөг хэлэлцэж баталлаа

Ховд аймгийн ИТХ, Жаргалант сумын ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Жаргалант сумын ЗДТГ, “Жаргалант хатан заяа” эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран “Цахим орчинд хүүхэд хамгаалал” арга хэмжээг зохион байгуулж байгаа бөгөөд нэгдүгээр шатны ажил болох ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Цахим орчин–Миний амьдралд” сэдэвт сэдэмж бичлэгт гар зургийн уралдааныг зохион байгуулан ажиллаж байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого Жаргалант суманд зохион байгуулагдаж нийт 22 тоологч 5 шалгагч 12 баг дээр ажиллаж 840 өрх сонгогдсоноос 857 өрхийн 3114 иргэн тооллогонд хамрагдсан байна.

Шинэчлэн батлагдсан төрийн албаны тухай хууль Засгийн газрын 37, 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган 2020 оны ЗДТГ-ын болон төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталлаа.

Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр:

Улс, аймгийн “Аварга тариаланч”, “Аварга малчин өрх” шалгаруулах журмын дагуу “Улсын аварга тариаланч”-аар 1, улсын “Аварга малчин өрх”-өөр 1, аймгийн “Аварга тариаланч”-аар 3, аймгийн “Аварга малчин өрх”-өөр шалгаруулахаар 2 малчны материалыг тус тус бүрдүүлж аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу үндэсний үйлдвэрт арьс шир тушаасан малчин болон мал бүхий өрхийн 45 баримтыг хүлээн авч “ARIS” программд шивж холбогдох материалыг бүрдүүлэн аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

Аймгийн Мал эмнэлэгийн газрын дарга, Жаргалант сумын Засаг даргын хамтран баталсан удирдамжийн дагуу 12 багийн нутаг дэвсгэрт байгаа гэрийн тэжээвэр нохой, мууранд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, бүртгэлжүүлж гэрчилгээжүүлэх, актлах, өндгөвч авах ажлыг үргэлжлүүлэн хийж 1 дүгээр сарын байдлаар 58 нохой, муурыг бүртгэлжүүлэн гэрчилгээ, пайз олгоод байна.

Байгаль орчны чиглэлээр:

Сумын Засаг даргын 2020 оны А/06 дугаар Захирамж “ Албан байгууллага, аж ахуйн нэгж өөрийн эзэмшил газар болон түүний ойр орчны 50 метр хүртлэх газрын хог хаягдал , цас мөсийг цэвэрлэх “-ийг хүргүүлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2019 оны агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогын ажлыг 12 багийн Засаг дарга , нийгмийн ажилтан нартай хамтран айл өрхөөр орж асуулгыг Байгаль орчин , аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 тушаалын 1 дүгээр маягтын дагуу авч ажиллаж байна. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогын тоо бүртгэлийн дүн мэдээг 02 дугаар сарын 10-нд нэгтгэн Ус, Цаг уур, орчны шинжилгээний төвд хүргүүлнэ.

Зэрэг сум:

Сумын Засаг даргын Тамгын газар аппаратын хурлыг 01 дүгээр сарын 02-нд зохион байгуулж өнгөрсөн оны ажлын ололт амжилт, алдаа дутагдал, ирэх онд хийж хэрэгжүүлэх ажлын талаар сумын Засаг дарга болон Тамгын газрын дарга мэдээлэл хийлээ. Сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдуулж Улсын аварга малчин, аймгийн аварга малчин, аймгийн алдарт уяач, сумын аварга малчин, сумын алдарт уяачдыг тодорхойлон холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Монгол улсад Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн баярт зориулан сумын ИТХ, Засаг даргын Тамгын газраас 01 дүгээр сарын 13-нд ард иргэдэд Үндсэн хуулийн өөрчлөлт шинэчлэлт, шинээр батлагдан гарч байгаа хууль тогтоомжууд болон ЗДТГ-ын мэргэжилтнүүд салбарын хууль тогтоомжуудын талаар иргэдэд мэдээлэл хүргэж асуулт хариултын “АХА” тэмцээн, үдшийн цэнгүүнийг зохион байгуулан явууллаа.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан сум байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх ажлын хэсэг тус суманд 01 дүгээр сарын 23-ны өдөр ажиллаж төсөвт байгууллагын үйл ажиллагаа, багийн Засаг дарга нарын үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийлээ. Аймгийн Цагдаагийн газар, Прокурор, Шүүх, Гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Шүүхийн шинжилгээний албад хамтран 2019 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан болон шинээр батлагдан гарсан хууль тогтоомжуудыг сурталчлах ажлыг төрийн албан хаагчид болон иргэдэд 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулан явууллаа.

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг сумын аварга шалгаруулах тэмцээнийг Сагсан бөмбөг, Гар бөмбөг, Шатар, Үндэсний бөх гэсэн 4 төрлөөр зохион байгуулан явуулж нийт давхардсан тоогоор 200 гаруй тамирчид 68 багц медалийн төлөө өрсөлдөж аваргаа шалгарууллаа.

Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу Үндэсний үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмын дагуу арьс ширээ бэлтгэж үндэсний үйлдвэрт 2019 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн тушаасан баримтыг нэгтгэн 1 дүгээр сард нийт 337 малчин, мал бүхий өрхийн 767 ширхэг падаанд бичигдсэн 20283 ширхэг арьс, шир үүнээс 6811 ширхэг хонины нэхий, 12061 ширхэг ямааны арьс, 1045 ширхэг үхрийн шир, 366 ширхэг адууны ширийг арьс, ширний холбооны төлөөлөгчдөөс хүлээн авч, арьс, ширний урамшуулал олгох программд шивж оруулан баталгаажуулж 01 дүгээр сарын 13-ны өдөр хүргүүллээ. Арьс ширний урамшуулал авахаар баримт бүрдүүлсэн иргэдийн мал эмнэлгийн нэгжүүдээр бичүүлсэн, гарал үүслийн гэрчилгээнд баталгаажуулалт хийн ажиллалаа. Мөн иргэдийн регистрийн дугаар, дансны дугаар зэрэг мэдээлэл зөв бичигдсэн эсэх, малчны тэмдэг, үйлдвэрийн тамга, арьс, шир бэлтгэлийн төлөөлөгчийн тамга, тэмдэг бүрэн, гаргацтай дарагдсан эсэхийг хянаж материалыг иргэдээс хүлээн авсан байна. Иргэдийн харилцах дансны мэдээллийг банкуудаар гаргуулан баталгаажуулан хавсаргасан байна.

TNC байгаль хамгаалах олон улсын байгууллагын Ховд аймаг хариуцсан захирал, мэргэжилтэн нар 01 дүгээр сарын 18-нд тус суманд ажиллаж ОНТХГ нутаг болох Баатархайрханы нурууг хамгаалах менежмент төлөвлөгөөг сумын удирдлагууд, багийн Засаг дарга нар, иргэдийн төлөөллийн оролцоотойгоор хэлэлцэн баталлаа.

Хүн ам орон сууцны улсын тооллогыг 01 дүгээр сарын 09-15-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулан явууллаа. Уг тооллогыг түүврийн аргаар нийт хүн амын 10 хувьд нь зохион байгуулж 95 өрх хамрагдсан байна.

Эрүүл мэндийн төв: Тус сумын Эрүүл мэндийн төв нь 01 сарын байдлаар нийт 190 хүнийг үзлэгт хамруулснаас урьдчилан сэргийлэх үзлэгт 55,

диспансерийн хяналтанд 39 гэрийн дуудлагаар 6 хүнд тус тус үйлчиллээ. Хэвтэн эмчлүүлэгч болон үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй, чанартай, шинжилгээнд суурилсан стандарт эмчилгээ үзүүлэх зорилгоор 11 төрлийн шинжилгээг хийж байна. Эрүүл мэндийн төв нь Нийгмийн даатгалын сангийн 4 багцаар тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ба өдрийн эмчилгээнд 8, сэргээн засах эмчилгээнд 7, оношилгоо шинжилгээнд 91, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээнд 8 хүнд тус бүр тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

2020 оны 1 дүгээр сард Сум хөгжүүлэх сангаас төслийн зээл авах хүсэлтэй иргэдийн 8 төслийг хүлээн авсан бөгөөд Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 5 иргэнд 23 сая төгрөгийн зээлийг олгохоор төлөвлөөд байна.

Манхан сум:

Засаг даргын Тамгын газар:

Орон даяар зохион байгуулагдаж байгаа хүн ам, орон сууцны тооллогыг ажлын хэсэг 01 дүгээр сарын 09-15-ны хооронд, агаар бохирдуулах эх үүсвэрийн хяналтын нэгдсэн тооллогыг 1 сарын 13-23-ны хооронд хийж гүйцэтгэн дүн мэдээг хүргэсэн.

Сумын ИТХ, ЗДТГ, шинээр байгуулагдсан сумын тэмээчдийн холбоо хамтран 01 дүгээр сарын 12-нд “Тэмээний баяр” зохион байгууллаа. Тэмээний баярт аймаг, сумын удирдлагууд, Говь-Алтай аймаг, Увс аймгийн малчид мөн бусад сумдын малчид нийт 500 гаруй хүн оролцож 2 насны тэмээний уралдаан/их нас, тором/ , тэмээн буухиа, сайхан тэмээтэй хос шалгаруулах, тэмээний тухай дуу, шүлэг шалгаруулах зэрэг уралдаан тэмцээн зохион байгууллаа.

Ардчилсан шинэ үндсэн хууль батлагдсан өдрийг тохиолдуулан 01 дүгээр сарын 13-нд үндэсний бөхийн барилдаан болон “Дээлтэй монгол” үдшийн цэнгүүн зэрэг үйл арга хэмжээг зохион байгуулсан.

Аймгийн ЗДТГ-ын санхүү албаны дарга Ч.Багдалаар ахлуулсан хяналт, шалгалтын ажлын хэсэг 01 дүгээр сарын 19-нд суманд ажиллан ЗДТГ, төсөвт байгууллагууд болон багуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, ажлын хэсэг хяналт шалгалтын дүнг нэгтгэн хурал хийж, цаашид анхаарах, хэрэгжүүлэх зарим ажлын талаар зөвлөгөө өгч ажиллаа.

Аймгийн Засаг даргын төрийн албан хаагчид болон ард иргэдэд 2019 оны ажлын тайлан, 2020 онд хийж хэрэгжүүлэх ажлаа танилцуулах хурал уулзалтыг 01

дүгээр сарын 19-нд зохион байгууллаа. Уулзалтад төрийн албан хаагчид бүрэн хамрагдаж нийт 250 хүн оролцлоо.

2020 оны “Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл”-ийг 1 сарын 20-ноос эхлэн хийж байна.

Засаг дарга, Засаг даргын орлогч, бичиг хэргийн эрхлэгч, байгаль орчны байцаагч нар 01 сарын 22-ны өдөр төсвийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, үүрэг чиглэл өгч ажиллалаа.

01 сарын 23-ны өдөр Ховд аймгийн прокурорын газрын дарга итгэмжит зөвлөх Н. Доржсүрэнгээр ахлуулсан ажлын хэсгийн ард иргэд, албан хаагчидтай хийх уулзалтыг зохион байгууллаа. Тус уулзалтаар аймгийн шүүх, прокурор, цагдаагийн газрын жилийн ажлын төлөвлөгөө, тайланг танилцуулж, гэр бүлийн тухай хууль, зөрчлийн тухай хууль, эрүүгийн тухай хууль, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудаар мэдээлэл хийж иргэдийн дунд АХА тэмцээн зохион байгууллаа.

Хөдөө аж ахуйн тасаг:

1. Дээд шатны байгууллагуудаас ирсэн хугацаатай бичгийн хариуг цаг тухайд нь гаргаж хүргүүлсэн.

2. Улсын аварга малчны 2, аймгийн аварга малчны 5 нийт 7 аварга малчны материалыг зохих журмын дагуу бүрдүүлж аймгийн ХХААГ-т хүргүүлсэн.

3. “Их уулсын хүрэн тэмээ” зөвлөгөөнд оролцсон

4. Үндэсний үйлдвэрт тушаасан арьсны урамшуулалд хамрагдах малчин, мал бүхий иргэдын нэхэмжлэлийг нэгтгэж аймагт хүргэсэн.

5. 2020 оны инженерийн хийцтэй худгийн захиалга авч Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн

Мал эмнэлгийн тасаг:

Ховд аймгийн Мал эмнэлгийн газраас Бямбацогт ахлагчтай ажлын хэсэг ирж мал эмнэлгийн тасгийн 2019 онд хийсэн ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, ажлын гүйцэтгэл, санхүү, хөрөнгө шилжүүлэх, мөн үндэсний хөтөлбөрүүдийн биелэлтийг шалгаж дүгнэн, Мал эмнэлгийн тасгийн ажлыг үзлээ.

Мал эмнэлгийн нэгжүүдээс мэдээ тайлан батлуулан авч, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

2018-2019 мал эмнэлгийн нэгжүүдтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан, таригдсан малын жагсаалтыг мал эмнэлгийн нэгдсэн сиистемд шивж орууллаа.

2020 онд Мал эмнэлгийн нэгжүүдээс Мал, малын гаралтай түүхий эдэд гарал үүслийн бичиг олгуулсан. Маханд-3128 кг, арьс-4039, амьд мал-53 нийт 7220 мал, малыг гаралтай түүхий эдийг баталгаажуулсан байна.

Мал эмнэлгийн хяналт шалгалтаар хувийн хэвшлийн нэгжүүдэд хяналт шалгалт хийлээ. Дэлгүүр дэлгүүр цайны газар хяналт шалгалт хийнэ гарсан зөрчлийг тухай бүр арилгуулж ажиллаж байна.

Байгаль орчин:

Жил бүр улс орон даяар явагддаг агаарын бохирдолын тооллогыг сумын Засаг даргы захирамжаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Үйлдвэр үйлчилгээ явуулж байгаа цайны газруудад хог хаягдал болон ус ашиглалтын гэрээ байгуулан хамтран ажиллах талаар холбогдох газруудад мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна.

01 дүгээр сарын 12-нд хооронд сумын тэмээчдийн холбооноос тэмээний баяр зохион байгууллаа. Энэ үер 2 насны тэмээний уралдаан, тэмээн буухиа, сайхан тэмээтэй хос шалгаруулах, тэмээний тухай дуу шүлэг дуулах зэрэг уралдаан тэмцээн зохионбайгуулахад оролцлоо.

Ботгон багийн Таван овоо гэдэг газар хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэдийг таслан зогсоох арга хэмжээг авч ажиллаа.

Ерөнхий боловсролын сургууль:

1-р сарын 5–аас Бага ангийн сургалтын менежер Ж.Бямбасүрэн Говь-Алтай, Өвөрхангай, Улаанбаатар хотын сургуулиудын туршлага судлах, харилцан туршлага солилцох болон БМДИ-д бага боловсролын шинэчлэлийг дэмжих төвийн сургалтад, 1-р сарын 13-17-ны хооронд Бага ангийн багш Д.Цэцэгсүрэн Ховд аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдэд дохионы хэл заах арга зүй сургалтад хамрагдаж ирлээ.

Аймгийн БСУГ-аас ЭЕШ-ын сорилго 2–г зохион байгуулж явууллаа. 1-р сарын 7–нд сургуулийн захирал, менежер математикийн багш нар БСУГ-т математикийн сургалтын чанарыг сайжруулах талаар тайлан хэлэлцүүлж ирлээ.

ИЗОУИС-н оюутнууд тус сургуулийн 12-р ангийн сурагчдад мэргэжил сонголтын талаар мэдээлэл сургалт хийлээ.

Аймгийн ЗДТГ-н мэргэжилтнүүд байгууллагын Хяналт шинжилгээ үнэлгээ хийлээ. Багш ажилчид аймгийн засаг даргын ажлын тайлангийн хуралд суулаа.

Спортын цогцолбор:

Ховд аймгийн өндөр уулын бүсийн сумдын оюутан залуучуудын нөхөрсөг гар бөмбөгийн тэмцээнд 2020 оны 01-р сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тэмцээнд 7 сумын эрэгтэй 11 баг, эмэгтэй 7 баг нийт 18 багийн 150 гаруй тамирчид амжилттай өрсөлдлөө.

Эрүүл мэндийн төв:

Эрүүл мэндийн төв нь 4 их эмч, ажилтан 21, нийт 25 орон тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. 2020 оны 01 дүгээр сарын 21-ны байдлаар 294 үйлчлүүлэгчдэд амбулторын үзлэг шинжилгээ, урьдчилан сэргийлэх үзлэгээр 61 хүнд үзлэг хийсэн. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч 46 , төрсөн эх-0,6 алсын дуудлаганд үйлчилсэн байна. Томуу томуу төст өвчний тандалтын мэдээг 7 хоног бүр өгдөг. Товлолын дархлаажуулалтанд 15 хүүхэд , 0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавьж ажиллаж байна.

Соёлын төв:

Манхан сумын Баянгол багийн малчин Сумын начин Батхишигийн хүү Баяндалайд зориулсан хандивын тоглолт болсон. Сумын ард иргэд халуун сэтгэлээр хүлээн авж хүрэлцэн ирсэн сайхан тоглолт хийлээ. Тоглолтыг шууд Live хийж монголынхоо өнцөг булан бүрт байгаа манханчууд болон монголчууддаа дамжуулсан. Сумынхаа нийт ард иргэдийнхээ дунд дээлтэй монгол цэнгүүнийг зохион байгуулж сайхан дээлтэй хос, загварлаг хувцастан, Юндэн гөгөө, Нансалмаа зэрэг шилдэг оролцогчидоо шалгаруулж шагнаж урамшуулсан.

Ховд аймгийн засаг дарга баруун бүсийн дарга Дүгэржав ажлын албатайгаа ирж иргэд хөдөлмөрчидөд цаг үеийн байдлаар уулзалт хийсэн.

Цэцэрлэг:

Байгууллагын 2020 оны жилийн ажлын төлөвлөгөөний зорилтуудын хүрээнд хийгдэх ажлуудын саналыг багш, ажилчдаас авч тусгалаа.

Аймгийн БСУГ-аас ирүүлсэн байгууллагын гүйцэтгэлийн гэрээ боловсруулах арга зүйн зөвлөмжийг судалж гүйцэтгэлийн гэрээ боловсруулахад анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Байгууллагын дотоод журам, хамтын гэрээг хамт олноор хэлэлцүүлж дүгнэх, шинээр оруулах нэмэлтүүдийг журамд тусгаж баталгаажууллаа.

Тархалттай ханиад томууны улмаас Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу хүүхдүүдийг 10-наас 20-ны өдрийн хугацаанд цэцэрлэгт аваагүй. /20-ны өдрөөс эхлэн ажиллаж эхэсэн ба хүүхдийн ирц 120 болж нэмэгдэж байна./

Багш, ажилчдаар хүүхдийн амралтын хугацаанд их цэвэрлэгээ, үйлчилгээ хийлгэлээ.

Багш нар бичиг баримтын сайжруулалт, боловсруулалтаа энэ хугацаанд хийлээ.

Мөнххайрхан сум:

Нэг. Хурал зөвлөгөөн сургалт, зохион байгуулалтын ажлын талаар:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдааныг 2 удаа хуралдуулж, 6 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, Засаг даргын Тамгын газрын аппаратын шуурхай хуралдааныг 3 удаа хуралдуулж, цаг үеийн ажлын талаар хэлэлцэн, үүрэг чиглэл өгч ажиллав.

Сумын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Дэд бүтцийг сайжруулж, иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлэх жил” болгон зарлаж 2020 онд тус сум “Аймгийн тэргүүний сум”, “Гэмт хэрэг, зөрчилгүй сум” болох зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Үндсэн хуулийн өдрөөр шинэ үеийн үндсэн хуулийг сурталчлах түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын удирдамж гаргаж, сумын Засаг даргын нэрэмжит 5 төрөлт спортын тэмцээн, “Үндсэн хуулийн үнэ цэнэ” сэдвээр насанд хүрэгчдийн дунд эсээ бичлэгийн уралдаан зарлаж, Урианхай сур, шатар, гар бөмбөг, дардасын тэмцээнүүдийг зохион байгуулж, бүх нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, үндсэн хуулийн талаар иргэдэд сурталчлах, 2019 онд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар иргэдэд тайлбарлан таниулах ажил хийж, нийт 200 гаруй иргэд оролцов.

Манхан сумын спорт цогцолборт 01 дүгээр сарын 15-ны өдөр бүсийн 5 сумдын дунд зохион байгуулагдсан гар бөмбөгийн аварга шалгаруулах бооцоот тэмцээнд эрэгтэй, эмэгтэй 2 баг оролцож, эрэгтэй баг тамирчид тэргүүлсэн амжилттай оролцов.

Аймгийн Засаг даргын орлогч Т.Жаргалсайханаар ахлуулсан ажлын хэсэг тус суманд ажиллаж, баг, албан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зөвлөмж өгч, сумын иргэдтэй уулзалт зохион байгуулж, 2019 онд Ховд

аймагт хийгдсэн бүтээн байгуулалт болон 2020 оны зорилт, цаашдын хөгжлийн талаар мэдээлэл хийлээ.

Аймгийн цагдаа, шүүх, прокурорын байгууллагуудын 2019 оны тайлангийн хурал 01 дүгээр сарын 22-ны өдөр болж, хуралд 110 хүн хамрагдав.

Сумын газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн 9 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Санхүү, төрийн сан, статистикийн ажлын талаар: Төрийн сангийн програмаар 9 байгууллагын 16 данснаас 29 ширхэг төлбөрийн хүсэлтээр 17376700 төгрөгийн гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгаж, шивлээ.

Хувийн мал эмнэлэгүүд, төрийн бус байгууллагууд, сүм, “Хайрхан бортын боргио” зэрэг аж ахуйн нэгжүүдийн 2019 оны 4 дүгээр улирлын мэдээг гаргаж, статистикийн хэлтэст хүргүүлэв.

Монгол улсын хэмжээнд 10 жил тутамд явагддаг Хүн ам, байшин, орон сууцны улсын ээлжит тооллого 01 дүгээр сарын 09-15-ны хооронд зохион байгуулж, сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэгт сумын шалгагч 1, 4 тоологчийн бүрэлдэхүүнтэй тооллогын ажлыг амжилттай гүйцэтгэв.

Тооллогын түүвэр судалгаанд 65 өрхийн 262 хүн хамрагдаж, тоологдохоос 65 өрхийн 231 хүн тоологдов. Хугацаат цэргийн алба хааж байгаа, өөр аймаг, хотуудад суралцаж байгаа, оюутнууд, иргэд тооллого хийх хугацаанд хаягандаа байгаагүй тул тоолоогүй байна.

Хоёр. Үйлдвэрлэл, үйлчилгээний талаар:

Сумын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах салбар зөвлөлийн хурлыг 01 дүгээр сарын 24-ний өдөр хуралдуулж, 2020 оны ажлын төлөвлөгөөгөө батлан, сар бүр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, зөрчлийг арилгах, хяналтын үр дүнд зөрчил, эрсдлээс иргэд үйлчлүүлэгчдийг хамгаалах, хэрэглэгчдийн болон үйлчилгээ эрхлэгчдийн хууль эрх зүйн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх ажил зохион байгуулахаар төлөвлөж, биллярд, мөрийтэй тоглоом тоглуулж байгаа иргэдтэй уулзаж, хууль, стандартыг танилцуулж, шаардлагыг хангуулах чиглэл өгч ажиллав.

Сум хөгжүүлэх сангаас 2019 онд зээл авсан иргэдийн зээлийн хувийн хэргийг бүрдүүлж, өмнөх зээлээ төлөөгүй иргэдийг шүүхэд өгч, 2 удаагийн шүүх хуралдаанд сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн төлөөлөн оролцов.

Зээлийн эргэн төлөлт 1 дүгээр сард 1 зээлдэгч 3.000.000 төгрөгний төлөлт хийсэн байна.

Гурав.Боловсролын салбарын хүрээнд:

Ерөнхий боловсролын сургууль аймгийн Засаг даргын А/07 дугаар захирамжийн дагуу хичээл сургалтын үйл ажиллагаа, сурагчдын амралтыг 7 хоногоор хойшлуулж, 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлж, дотуур байранд хүүхдээ хүлээн авлаа.

Галч нарын ажлын ачааллыг хөнгөвчилж, 1 галчийг нэмж ажиллуулж, тэтгэврийн насанд хүрсэн багш ажилтнуудтай шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулан томилж, сургуулийн захирлын сонгон шалгаруулалтанд захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батзаяа орж тэнцэв. Багш нар 9, 10, 11, 12 дугаар ангийн сурагчдад, бага ангийн багш нар зарим ангийн хүүхдүүдэд давтлага өгөв.

Амралтын хугацаанд сургуулийн багш нар ангиудыг цэвэрлэн хичээл эхлэх бэлтгэл хийж, ажилчид сургуулийн гадна орчны хог цэвэрлэж, дотуур байрны багш ажилчид тасаг байрыг угааж, их цэвэрлэгээ, ариутгал хийлээ.

Мөн хугацаанд багш ажилчдын дунд хөдөлгөөн, тэнцвэр, эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд багш ажилчдын спортын ур чадварыг дээшлүүлж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 4 төрөлт тэмцээн зохион байгууллаа.

Хүүхдийн цэцэрлэгийн багш нар “Суралцагчийн ялгаатай байдлыг сургалтанд харгалзах нь үйл ажиллагаа үр дүн” илтгэл бичиж хэлэлцүүлж, шалгарсан нэг илтгэлийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт хүргүүлсэн.

Багш нар сургалтын хөтөлбөрөө боловсруулж, аргачлал бичиж, аргачлалын дагуу хичээлээ явуулав.

Бага бүлэг “Хөгжөөн баясах, номын булан”, Дунд бүлэг “Ёс заншлын өргөө”, Бэлтгэл “А” бүлэг: Ном, Шагай, Морь,Тэмээ, Цэцэг сэдвүүдээр хийсэн 1-5 сард хүүхэд хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө, аргачлалуудыг хэвлэж хаяглаж, хавтасласан, Могойн шоо, Эв долоо, дүрслэх урлаг, даамын дугуйлан хичээллүүлж, “Хүүхдүүд 3-аар сүлжиж сурах” аян зохион байгуулж, 20 хүүхэд сүлжиж сурсан. Сүлжих хэрэглэгдэхүүн 10 ширхэг хийж, мөн хүүхдүүдээр “Миний ном” сэдэвт ном бүтээлгэж, “Хувцсаа эвхэж сурцгаая” аян өрнүүлж, 28 хүүхдээс 24 хүүхэд хувцсаа эвхэж сурсан байна.

Бэлтгэл “Б” бүлэг: Шүлгийн дугуйлангаар энэ сард 7 шүлэг заасан ба нийт хүүхдийн 80 хувь нь сурсан. Мөн Сэтгэхүйн дугуйлан хичээллүүлж, могойн

шоогоор Тахир шугам, Саваа мод, Зүрх, үсний хавчаар, Анааш зэрэг 5 дүрс бүтээж нийт хүүхдийн 70 хувь нь сурсан байна.

“Номын гэгээ” хөтөлбөрийн хүрээнд Хүүхэд бүр өөрийн нэрэнд орсон үсэг бичиж сурах ажлыг эхлүүлж, Авьяас хөтөлбөрийн хүрээнд “Барби” хөгжимт гимнастикийг 60 хувьтай сурч байна.

Хөгжмийн багш Б.Энхцэцэг-Гарын доорх материал ашиглан бөмбөрийн цохиур мод 20 ширхэг, “Морин уралдаан” шагайгаар тоглох тоглоом 15 ширхэг хийж ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг тоглуулахаар зэхэв.

Тогооч нар стандартын дагуу өрөө байраа тохижуулж, эрүүл ахуйн шаардлага хангаж, хүүхдэд амт чанартай хоолоор үйлчилж, хоолны цэсийг 7 хоноогоор шинэчилж, эрхлэгчээр тогтмол батлуулж ажиллсан.

Багш ажилчид хамтран цэцэрлэгийн орчны хогийг цэвэрлэж, галч нар нүүрс, аргалын хогоо ачиж, дотно гадна ариутгал хийсэн.

Дөрөв.Эрүүл мэндийн үйлчилгээний талаар:

Эрүүл мэндийн төвд нийт 35 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Эмийн бус эмчилгээгээр 61 хүнд үйлчилсэн. Урьдчилан сэргийлэх зорилгоор: 0-2 насны 31 хүүхдэд товлолын дагуу дархлаажуулалтанд 100 хувь хамруулсан.

Улирлын томуугийн дэгдэлт их байгаатай холбоотойгоор эмнэлгийн орыг нэмэгдүүлж эмч, ажилчид уртасгасан цагаар, амралтын өдрөөр ажиллаж байна.

Амбулаторийн үзлэгийг гэрийн үзлэгт шилжүүлж багийн бага эмч нар гэрээр явж эмнэлгийн тусламж үзүүлж томуугаас сэргийлэх зөвлөмж гарын авлага тарааж ажиллаа. 2020 онд ажиллах бүтэц, бүрэлдэхүүн цалингийн тогтоомж батлах хурлаа хийж үндсэн 21 гэрээт 4 орон тоотойгоор ажиллахаар батлав. “Томуугаас урьдчилан сэргийлэх”, “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” сургалт, сурталчилгааг 0-5 насны хүүхэдтэй 30 эцэг, эхчүүдэд нийгмийн эрүүл мэндийн танхимд зохион байгуулсан.

Тав.Урлаг соёлын үйлчилгээний талаар:

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг малчдын дундах гар бөмбөгийн тэмцээний шагнал гардуулах ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаанд зориулсан шоу цэнгүүн 01 дүгээр сарын 09-ний өдөр хийж, 200 гаруй хүн, Монгол улсын соёлын тэргүүний ажилтан Баатарын “Алтан хөхийн дуулал” уран бүтээлийн тоглолт тоглогдож, 150 насанд хүрэгчид, 36 хүүхэд багачууд үзэж сонирсон. “Бүжиглэх өдөр” бүжгийн цэнгүүнийг 01 дүгээр сарын 17-ны 19.00 цагаас зохион байгуулж, цэнгүүнд 14 бүжигчин оролцов.

Сумын 2020 оны үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу мэргэжлийн бүжгийн багш Б.Батмарал бүжгийн дугуйланг 30 хүүхэд, М.Эрдэнэбат морин хуурын дугуйлан хичээллүүлж 12, Г.Бат-Эрдэнэ хөөмий, цуурын дугуйланг хичээллүүлж, 3 хүүхэд хөөмий, 1 хүүхэд цуур сурлаа. Сарын хугацаанд 3 тоглолт, 3 баярын цэнгүүн, 2 шоу цэнгүүн, 3 удаагийн хурал зөвлөгөөн, 3 сургалт дугуйлан хичээллэж, уг үйл ажиллагаануудад давхардсан тоогоор 1962 иргэн оролцсон байна.

Тав. Байгаль орчны чиглэлээр:

Бүс нутагт “Алтайн хойлог шувуу” хамгаалах аяны хүрээнд ДБХС-тай хамтран хойлогны хоноглох цэгийн судалгаа гаргаж, хяналтын 22 ш автомат камерийг хязгаарлалтын бүсэд 7ш, орчны бүсэд 15ш камер байрлуулсан.

Байгаль хамгаалагч нар 1 дүгээр сарын 10-15-ны хооронд хариуцсан бүс нутагтаа байрлуулсан камерийн зай, карт солих, бүртгэгдсэн мэдээллийг цуглуулах ажлыг хийсэн. Автомат камерийн цуглуулсан мэдээлэлд орсон зөрчил гаргахыг завдсан 11 иргэнийг хамгаалалтын захиргааны улсын байцаагч нар дуудан уулзаж, хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан. Хамгаалалтын захиргаанаас нэн ховор, ховор Алтайн хойлог, ахууна зэрэг шувуудыг хамгаалах талаар гарын авлага бэлтгэн олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Хамгаалалтын захиргаа Мөнххайрхан сумын ЗДТГазар, албан байгууллагуудтай хамтран 1 дүгээр сарын 17-ны өдөр сумын төв орчмын хог хаягдлыг цэвэр ажлыг тус суманд зохион байгуулан ажиллалаа. Ажлын хүрээнд 3 тн хог хаягдал цэвэрлэж, нэгдсэн хогийн цэгт буулгасан.

Сургалт, сурталчилгааны ажил: Баян-Өлгий аймгийн Булган хэсгийг хариуцсан байгаль хамгаалагч нар байгаль хамгаалах Баянхавцал, Тунгалаг Төргөн нөхөрлөлүүдтэй хамтран Булган сумын Сөнхөл багийн иргэдийн дунд үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ уламжлуулах зорилгоор гар аргаар хийсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргаж, Урианхай сурын мөсний харваа, зуун цааст хөзөрийн тэмцээн зохион байгуулан, олон нийтэд байгаль орчны талаар мэдээлэл өгч, гарын авлага тараан сурталчлах ажлыг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд нийт 300 хүн оролцсон.

Сумын ЗДТГ-аас БОАЖСайдын 2018 оны А/1479 дугаартай тушаалын дагуу агаарын бохирдлын нэгдсэн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулан, нэгдсэн тооллого хийж байна.

Зургаа. Багуудад хийгдсэн ажлууд:

Борт багийн ИНХ-ыг 01 дүгээр сарын 21-ний өдөр хийж, багийн Засаг даргын 2019 оны ажлын тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгч, 2020 оны ажлын зорилго, зорилт, үйл ажиллагаагаа төлөвлөв. Хадгаламж зээлийн хоршоо байгуулах, малчдын дундын хоршооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, хаваржаанд орох хугацаа, хуц, ухна гэрээгээр ялган маллах, багийн дундын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, бүтээлч санаачилга зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Сэнхэр багийн ИНХ-ыг 01 дүгээр сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулсан багуудын малчин залуучуудын спортын 3 төрөлт уралдаанд амжилттай оролцож, үндэсний бөх, эмэгтэй гар бөмбөг, шатарын тэмцээнүүдийг тэргүүлж, нийлбэр дүнгээр тэргүүн байр эзлэв.

Найм. Мал эмнэлэг, хөдөө аж ахуйн чиглэлээр:

Малчны тамга захиалсан 4 иргэний тамгыг захиалж, хүлээлгэн өгөв. Арьс ширний урамшуулалд хамрагдах 236 өрхийн 1040 шир, 6943 богийн арьсны падан хүлээн авч, цахим санд оруулж, тайлан мэдээллийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүлээлгэн өгөв. Аймгийн аварга малчин 4, хошой аварга малчин 1, нийт 5 малчны шагналын тодорхойлолтыг гаргаж, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн аймгийн Засаг даргад санал уламжлав.

Хөдөө малчдаар эргэж, өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцав. Суманд нийт 122 мянган толгой мал өвөлжиж байна.

Сумын хэмжээнд золбин, эзэнгүй нохой устгах аян зарлаж нийт 14 нохой устгау ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

Мянгад сум:

Нэг: Засаг даргын Тамгын газрын мэдээлэл

1 дүгээр сарын 05-нд Төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл гомдлын мэдээг гаргаж дээд байгууллагад хүргүүллээ. 2019 онд нийт 1051 өргөдөл хүлээн авч зохих эздэд нь шийдвэрийн талаар мэдээлэл хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллалаа. Мөн 2019 онд хөтлөгдөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бичгүүдийг ангилан төрөлжүүлж архивт хүлээлгэн өгч данс бүртгэлийг хөтлөн 2020 онд хөтлөгдөх хэргийн нэрийн жагсаалтыг ББНШК-ын 01 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

1 дүгээр сард Засаг даргын Тамгын газарт иргэдээс 52 өргөдөл хүлээн авч биелэлтэнд нь хяналт тавин Бүртгэл хяналтын карт хөтлөн ажиллаж байна.

2.Улсын бүртгэлийн ажлын талаарх мэдээлэл

Иргэний гэр бүлийн бүртгэл, улсын бүртгэлийн чиглэлээр төрөлт 5, нас баралт 1, гэрлэлт 1, шилжин ирсэн 13, үрчлэлт 2, иргэний цахим үнэмлэх шинээр 1 25/45 насны сунгалт 10, гээгдүүлсэн 1, иргэний үнэмлэх олголт 14, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн Газрын гэрчилгээ 1, нийт 49 иргэний өргөдөл материалыг хүлээн авч бүртгэлд хамруулан гэрчилгээжүүлээ.

3.НД-ын мэдээлэл

1 дүгээр сард төвлөрсөн санд 28520,0 мянган төгрөгийн орлого оруулсан.Үүнээс шимтгэлийн орлого 25052,3 мянган төгрөг, сайн дурын даатгалд 38 иргэнээс 2580,2 мянган төгрөг, ЭМД-д 25 иргэнээс 887,8 мянган төгрөг тус тус орууллаа.

Тэтгэвэр тогтоолгох өргөдөл 1 дүгээр сард 18 иргэнээс хүлээн авч хариуг хугацаанд нь барагдуулж тэтгэвэр тогтоолтыг хийлээ.

НД-ын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 155919,8 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврийн 384 хүнд 125528,1 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 33 хүнд 9620,0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 65 хүнд 20771,7 мянган төгрөг, ҮОМШӨ-ний сангаас 2 хүнд 1272,5 мянган төгрөг тэтгэмжийн даатгалын санд 4250,9 мянган төгрөгийн санхүүжилт жирэмсэн, амаржсаны тэтгэмжийг 2 хүнд 4125,5 мянган төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 2 хүнд 125,4 мянган төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг тус тус олголоо.

4.Хөдөө аж ахуйн тасгийн үйл ажиллагааны мэдээлэл:

2020 оны мал тооллогоор малчин өрх 719, малтай өрх 948, нийт хүн 3663 хүн амтай.Нийт мал 227695 толгой малтай байна. Нийт мал сүргийн таван төрөл тус бүрд нь авч үзвэл тэмээ 1393, адуу 11956, үхэр 14409, хонь 82362, ямаа 117575 толгой мал тоологдсон мэдээг өгч ажиллалаа. Аймгийн Засаг даргын 2017 оны А/37 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн хошой авларга, аварга малчин, аварга саальчин, аварга фермер, аймгийн аварга тариаланч хамт олон, аварга тариаланч шалгаруулах журам”-ын дагуу сумаас 7, аймгийн аварга малчны тодорхойлолтыг бүрдүүлэн материалыг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргэж ажиллалаа.

Малчин мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу тус сумын малчдын арьс шир, тушаасан нийт 16 өрхийн баримтыг программд шивж аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албанд архивын баримт болгон бүртгүүлж хүлээлгэн өгч ажиллалаа.

5.Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны мэдээлэл

Тус эрүүл мэндийн төв нь 01 дүгээр сарын 01-27 ны хооронд дараахь ажил үйлчилгээг хийж гүйцэтгэсэн байна.Энэ сард нийт 200 амбулаторийн үзлэг хийж нийт 31 иргэнийг хэвтүүлэн эмчилж, нийт 7 алсын дуудлаганд явж үйлчилсэн байна. Мөн 0-3 сартай 4 жирэмсэн эхийг эрт хяналтанд авч, 2 эхийг эсэн мэнд төрүүлж ажиллалаа.

Товлолын дархлаажуулалтыг шинээр төрсөн 2 хүүхдэд БЦЖ, В гепатит, Халдварт саа, 2 сараас -4 сартай нийт 20 хүүхдэд -Тавт вакцин, Саа-гийн вакцин Пневмококкийн эсрэг вакцин, 9 сартай – 7 хүүхдэд Улаанбурхан, Улаануудын эсрэг, Пневмококкийн эсрэг вакцин, 1,2 настай - 12 хүүхдэд –А гепатитын эсрэг вакцин, 2 настай 7 хүүхдэд Улаанбурхан, Улаануудын эсрэг вакцины 2 дахь тун, Саа-гийн идэвхгүйжүүлсэн вакциныг нийт 5 сартайд 5 тунг тус тус тарьж нийт 53 хүүхдийг товлолын дагуу дархлаажуулалтанд тус тус хамруулсан.

Эрүүл мэндийн даатгалаас санхүүждэг тусламж үйлчилгээ болох Өдрийн эмчилгээнд 8, Сэргээн засах тусламж үйлчилгээнд 13, Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээнд, Оношилгоо шинжилгээнд нийт 302 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Энэ сард хөдөөгийн багийн 35 өрхөд эрүүл мэндийн явуулын тусламж үйлчилгээг үзүүлж нийт 105 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг хийж товлолын дархлаажуулалтыг 53 хүүхдэд хийж ажиллав.

Шинээр илэрч байгаа Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг нийт 63 үйлчлүүлэгчдэд тарааж иргэдэд мөн иргэдэд гар угаах арга техникийг зааж заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Мөн эмнэлгийн нийт 15 мэргэжилтнүүдэд Коронавирусын халдварын үед авах арга хэмжээний тухай дотоодын сургалт хийж бэлэн байдлыг хангаж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

6.Ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл

Тус сургууль нь сургалт хүмүүжлийн ажлаа хуваарийн дагуу явууллаа.Энэ сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

1.4 дүгээр ангийн сурагчдаас анги нийтийн чанарын үнэлгээний судалгаат шалгалтыг Ховд аймгийн Жаргалант сумын Прогресс сургуультай хамтран зохион байгуулж авлаа.

2.Хөгжмийн хичээлээр 3 дугаар ангиас чанарын үнэлгээний шалгалт авч анализ хийж аймгийн Боловсрол соёлын газарт явууллаа.

3.элсэлтийн ерөнхий шалгалтын сорилыг физик, хими биологи, түүх, нийгэм, газар зүйн хичээлээр 12 дугаар ангийн сурагчдаас сорил авч явууллаа.

4.Ахмад багш Дарьжавын Нямжавын нэрэмжид “Бяцхан тоочид” математикийн олимпиадыг 1 дүгээр сарын 13-наас 04 дүгээр сарын 13-ны хүртэл 2 үе шаттайгаар зохион байгуулахаар ажлаа төлөвлөн ажиллаж байна.

5.Сургуулийн түүхт 90 жилийн ойтой холбогдуулан Монгол улсын төрийн дээд шагналд багш нарыг тодорхойлон материалыг сумын ИТХ-д хүргүүлээд байна.

Үенч сум:

Засаг даргын Тамгын газраас 1 дүгээр сарын эхнээс суманд Агаарын бохирдлын тооллого, хүн ам орон сууцны тооллогыг ажлын хэсэгүүд байгуулж ажиллав. Ховд аймгийн Үйлдвэрчний эвлэлийн дарга Ариунжаргал ирж байгууллагууд хуралд 100 хувийн ирцтэй оролцож сумын Үйлдвэрчний эвлэлийн хороог байгуулав.

Мөн Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хуулиудаар сургалт хийлээ. Үндсэн хуулийн ойн өдрийг тохиолдуулан Байгууллагуудын дунд Нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран “Төрийн албаны тухай хууль, Монгол улсын үндсэн хуулиар сургалт зохион байгуулж, “АХА” тэмцээн явуулж эхны хоёр байрыг шагнаж урамшуулав. Сумын Засаг дарга багуудад очиж ажиллав.Засаг даргын захирамжаар байгууллагууд замын дагуу хатуурсан цасыг цэвэрлэв.

Ховд аймгаас сумын Засаг даргын Тамгын газарт хяналт үнэлгээний шалгалт ирж ажиллав. 01 дүгээр сарын эхнээс байгууллагын бүх ажилчид ажлын төлөвлөгөөг жил, улирлаар төлөвлөн гаргаж байгууллагын даргаар батлуулан ажиллаж байна.

Томуугийн дэгдэлт ихсэж байгаатай холбоотой 01 сарын 10-наас эмч нарыг шаардлагатай тохиолдолд уртасгасан цагаар ажиллуулсан.

1 дүгээр сарын 06-нд Улиаст багийн иргэдэд сургалт сурталчилгаа хийсэн.

Эрүүл мэндийн төвийн эмч нарын комисс байнгын асаргаа шаардлагатай 81 хүнд асаргаанд орох комиссын шийдвэр олгосон.

ЭМТ-ийн өмч хөрөнгө, тоног төхөөрөмжийн тооллогыг 1 сарын 14-15 ны хооронд өмч хамгаалах зөвлөлийн гишүүн Т.Отгонбаяр, С.Жагир нарын хамт 2 өдөр тооллого хийн, шинээр ирсэн хөрөнгийг орлогод аван, ажилчдад хөрөнгийн ашиглалтын картыг шинээр хөтөлж, өрөө өрөөнд нь хүлээлгэн өгөв

ЭМТ-ийн эмч эмнэлгийн мэргэжилтэн 16 ажилтанд Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаалын нэгдүгээр хавсра “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” сэдэвт, “Эх, хүүхэд НҮЭМ” үндэсний хөтөлбөр, ЭМС-ын 2014 оны 10 сарын 20 ны 338 дугаар тушаал “Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний” журмын хүрээнд жирэмсэн 15 ээжид сургалт явууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн сурагчдад эх баригч Д.Буянхишиг, бага эмч С.Чулуунцэцэг нар нийгмийн эрүүл мэндийн сургалтын хүрээнд “Хүүхэд нас хамгийн эрхэм” сэдвээр сургалт хийлээ. Сургалтанд 31 сурагч, 2 багш оролцов.

Байгууллагын ажилтнуудын хувийн хэргийг шинэчилж стандартын дагуу баяжилт хийв.

Боловсрол соёл урлагийн газарт 2020 оны тайлан гаргаж хүргүүлэв. Аймагтаа 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлаараа 3 дугаар байр эзлэв. Хөдөлмөрийн дотоод журмаа шинэчлэв. Хуучин оны бичиг баримтыг үдэж архивлах ажил хийгдэж байна.Эвдэрч хагарсан хаалга, сандал ширээгээ засаж сэлбэлээ. Корона вирус гарсантай холбогдуулан бүх өрөөнүүдэд ариутгал хийв.

Хоёр. Соёлын өвийн талаар:

Орон нутаг судлах музейн хадгалалт, хамгаалалтанд анхаарч иргэдээс хандивласан 5 ширхэг үзмэрийг хувийн дугаар, шинж тэмдэг, чанарыг тодорхойлон урт, өргөн, өндөр, диаметр, үнэлгээ зэргийг бичиж ерөнхий бүртгэлд бүртгэж хаягжууллаа.Музейн 5 ширхэг дурсгалын туганд суурь гагнуулж байрлууллаа. Мөн сумын соёлын биет болон биет бус өвийн өвлөн уламжлагчдын бүртгэлд шинээр 4 хүнийг бүртгэж баримтжууллаа. Музей, СББӨ-ийг өвлөн уламжлагчдын шинэчилсэн бүртгэл судалгааг гаргаж аймгийн музейн соёлын өвийн төвд хүргүүллээ.

Гурав. Номын сангийн талаар:

Сургуулийн хүүхдүүдийг амраасантай холбогдуулан номын сангаас уншигчдад гэрээр карт нээж ном олгож байна.

Мөн нутгийн зохиолчдын зохиосон номын булан гаргаж, ном зүйг нь бичиж гаргалаа. Каталогийн 100 ширхэг картыг хэвлэн гаргаж техник ажиллагаа хийсэн.

Бага ангийн сургалтын менежер Д. Мядагмаа Ховд аймгийн бага ангийн менежерүүдийн туршлага судлах аялал буюу БМДИ-ээс зохион байгуулсан сургалтанд хамрагдлаа.

Багш нар багш хөгжлийн төлөвлөгөөг заах аргын нэгдлийнхээ ажлаараа хэлэлцэн баталгаажуулав. Багш нар 1 дүгээр сарын 2-нд “Суралцагчдын ялгаатай байдлыг сургалтанд харгалзах нь” сэдэвт илтгэлийн 1-р шатны шалгаруулалтыг хийж бага ангийн багш М. Даваажав, Б.Ууганцэцэг, Т.Баяржаргал нарын хамтарч бичсэн илтгэл 2-р байранд шалгарлаа.

3 дугаар ангийн сурагчдаас дуу хөгжмийн хичээлээр чанарын үнэлгээний урьдчилсан шалгалт авч засан дүн анализ хийж БСУГ-т хүргүүлэв. 2 дугаар улирлын амралтаар бага ангийн багш нар хоцрогдолтой байгаа сурагчиддаа нэмэлт давтлага өгч ажиллаа. Мөн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг засаж сайжруулж хамтран ажиллаж байна. 1-р сарын 15-нд бага ангийн сургалтын менежер Д. Мятагмаа бага ангийн багш нарт “Блупринт хэрхэн зохиох талаар сургалт явуулан одоо даалгаврын сангаа боловсруулан ажиллаж байна.

Сургуулийн номын санд ирсэн 6-12-р ангийн 17 төрлийн 1014 ширхэг түрээсийн сурах бичгийг 78 сурагчдад олгов. 1-12 дугаар ангийн суралцахуйн удирдамж гарын авлага 211 номыг аймгийн БСУГ-аас татан авч данс бүртгэлд тусган багш нарт олголоо.

Багш нарын амралтын хугацаанд хийх ажлын төлөвлөлтийг гаргаж, 2-р хагасын дүн, ЭЕШ-ын сорилгуудын анализуудын нэгтгэл, цээж бичгийн шалгалтын нэгтгэлийг гаргаж багш сурагчдад танилцуулан ажиллав. Сургалт, хурал, бусад ажлуудад багш нараа идэвхтэй оролцуулан ирцийг бүртгэн ажилласан.

1 дүгээр хагас жилийн үнэлгээнээс үзэхэд VIII-43, VII-103, VI-107, V-101, IV-51, III-8, II-0, I-0 түвшний нийт ахлах дунд ангийн дунд 413 хүүхэд шалгагдлаа. 1 дүгээр сарын 02-нд “Суралцагчдын ялгаатай байдлыг сургалтанд харгалзах нь-үйл ажиллагаа үр дүн” сэдэвт сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдааныг зохион байгуулж илтгэлд 6 баг оролцлоо.

01 дүгээр сарын 06-нд сургуулийн 2019 оны ажлын тайлан хэлэлцэж нийт багш ажилчид үнэлэлт дүгнэлт өглөө. Засаг даргын захирамжийн дагуу нийтийн гудамж талбайны цас цэвэрлэлээ.

Ховд их сургуулийн гадаад хэлний багш Б. Энхжаргал багш нарт “21-р зууны боловсролын чиг хандлага” сэдэвт лекцийг хамтран зохион байгуулж нийт 27 багш оролцлоо.

3-р улирлын хичээлийн хуваарийг шинэчлэн гаргаж багш нарын цагийг тооцон ажиллаж байна. 2 дугаар улирлын амралтаар өгсөн ажлын чиглэлийн дагуу

багш нарын нэгж хичээлийн хөтөлбөр, даалгаврын сан, блюпринт, ТӨМ, ээлжит хичээлийн бэлтгэлийг хянаж арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллав.

Мэргэжлийн хичээлийн олимпиадын хуваарь гаргаж бэлтгэл ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

Боловсролын мэдээллийн системд сургуулийн орчны судалгаа, СУ-17 номын сангийн тайлан, БДБ18 сургалтын орны тайланг бодож илгээлээ. ХИС-ийн оюутан Н. Золзаяагийн “Бийрийн бичлэг”-ийн сургалтанд монгол хэлний багш нар сурагчд хамрагдан суралцаж байна.

Улсын физикийн 33-р олимпиад Ховд аймагт болохтой холбогдуулан физикийн туг сургуульд аялж байгаатай холбогдуулан физикийн багш нар сургуулийн захиргаатай хамтран олон ажлуудыг төлөвлөн зохион байгуулж ажиллав.

Заах аргын нэгдлийн ажлаар нийт багш нарт 1-р хагас жилийн үнэлгээ, ЭЕШ-ын анализын нэгтгэл цаашид хэрхэн ажиллах талаар санал, цээж бичгийн шалгалтын анализын нэгтгэлийг танилцуулж Үнэлгээний шинэ журам, Блюпринтыг хэрхэн зохиох, даалгавраа хэрхэн боловсруулах талаар сургалтуудыг зохион байгууллаа.

БСУГ-аас 10-р ангиудаас хими, биологийн хичээлээр түвшин тогтоох шалгалт, 12-р ангиудаас химийн хичээлээр сорилго-2 шалгалтыг авч анализыг хийн мэргэжилтэн лүү явууллаа. Мөн 9-р ангиудаас цээж бичгийн шалгалтыг авч анализ хийж ажиллав.

Багш, ажилчдын 1-р сарын цагийн тооцоог гаргаж арга зүйн цагийг тооцов. БСУГ болон бусад газраас ирсэн бичгийг хүлээн авч тухай бүрт нь ажлыг зохион байгуулж тайлан мэдээг цаг тухайд бичиж явуулсан болно. Сургуулийн сэтгэл зүйчийн ажлын байрын сонгон шалгаруулалт зарлагдаж байна. БНХАУ-д шинэ короновирус гарсантай холбоотойгоор 1 дүгээр сарын 27-ноос 3-р сарын 2-ныг хүртэл хичээл амарч, сургууль, дотуур байр, анги танхим, өрөө тасалгаандаа их цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтэл хийгдэж байна. Амралтын хугацаанд 2-р сарын 3-наас телевизийн сувгуудаар гарах “Теле хичээл”-ийг үзэх нөхцөл боломжийг ханган ажиллаж байна.

Сургалт хүмүүжлийн талаар

Хүүхдийн цэцэрлэг нь 1-р сард сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг төлөвлөлтийн дагуу чанартай явуулж ажлын төлөвлөгөөг сар, улирлаар төлөвлөж баталгаажуулан, хүүхэд бүрийн ахицын судалгааг гарган хүүхэд нэг бүрийн

онцлогт тулгуурлан тоглоомын аргаар үйл ажиллагаагаа явуулан, цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэн тухай бүр үзүүлэн, тарааж өгөх материал хийж хүүхдүүдээр бүтээл хийлгэн хавтасжуулсан. Хүүхэд нэг бүрт энгийн дадал хэвшил эзэмшүүлэх, заасан дуу шүлэг, хэлбэр дүрс, цифр таниулах ялгуулах өглөөний дасгал, оройн хөгжөөн баясгах ажил зэргийг тогтмол хийлгэж харилцах дэвтэр гарган ажиллаж байна. Мөн 3-5 хүүхдийг үлгэрийн тоглолтоор дамжуулан эх хэл,эх ороноороо бахархах, өөрийгөө, аав ээж, ах эгчээ танилцуулах найз нөхдөө хүндлэх туслах аргад суралцуулав. Багш нар нээлттэй хөгжүүлэх үйл ажиллагааг явуулж хэлэлцэв.Туслах багш нар дугуйлан хичээллүүлэв. Бүлэг тус бүр даавуун тоглоомтой болсон. Ахлах "а" бүлэг Номын тавиур, Эмийн булан, Бага "А" бүлэг тавиур 2ш, Бэлтгэл "А" Тавиур 2ш, Буйдан 1ш, Дунд "Б", Бэлтгэл "Б" Ахлах "Б", Дунд "А", Бага "Б" буйдан, ангийн булан, гоожуур, Жижүүрийн булан , хормогч, элсний самбар, товшуур хөгжмийн уут, даавуун тоглоомыг авч сургалтанд ашиглаж байна.

Багш ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар

Багш нар нээлттэй үйл ажиллагаа явуулан туршлага солилцож мэргэжлийн холбогдолтой хэвлэл, ном, захиалан сургалтанд ашиглаж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэн ажиллаж байна. Багш нарын дунд багш солилцоо явагдаж багш нар идэвхтэй сайн оролцож туршлага солилцов.

Эцэг эхтэй ажиллах

Багш ажилчдын шуурхай хурал зөвлөгөөнд цаг тухай бүрт оролцож ирсэн.Мөн сумын Эрүүл мэндийн төвөөс ирсэн үзлэгт цэцэрлэгийн бүх хүүхдүүдийг Амны хөндийн үзлэгт бүрэн хамрагдаж ,өвчтэй шүдтэй хүүхдийг эмчлүүлэх талаар эцэг эхтэй хамтран ажиллаж байна.

Бусад ажлын талаар

Хөтөлбөрүүдийн самбар гаргаж жил, сарын ажлын төлөвлөгөө гарган ажиллав. Ахмадуудыг хүлээн авав. Бэлтгэл "Б" бүлгийн хүүхдүүд хувцсаар жигдэрлээ.

Номын гэгээ"хөтөлбөр хүрээнд хийсэн ажил:

"Номын гэгээ" хөтөлбөрийн төлөвлөгөөг жил, сараар төлөвлөн баталгаажуулж тайланг сар бүр явуулж ирсэн. Бүлгүүд том ном , жижиг ном, даавуун ном хийж сургалтанд ашигласан. Мөн хүүдүүдийг номын төвд ажиллуулан урагдсан номыг наалгаж засаж сэлбэсэн. Заасан оньсого, таавар, ертөнцийн гурав, түргэн хэллэгийг сургалты явцад зааж сургасан. Эцэг эхийн дунд

“Үүргэвчтэй цүнх, дэлгэмэл ном”, үлгэрийн номын аян явуулан хүүхдүүдийн бүтээлийг ном болгон хавтасжуулсан.

“Авьяас” хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажил:

1. Найрал дуу хөгжмийн энгийн зэмсгийн хамтлагт хүүхдүүдээ оролцуулсан.
 2. Хүүхдийн цэцэрлэгийн туслах багш нар хүүхдүүдийн дунд зураг наамал, даам, шатар, шагайн дугуйлан явуулж хүүхдийг хөгжүүлж байна.
 3. Хүүхдүүдийн дунд “Аха,” “уран уншлага” –ийн тэмцээн ахлах А, Б, бэлтгэл Б бүлгийн хүүхдүүдийн дунд явагдав.
 4. Ардын уламжлалт тоглоом тэмээн тохош, нар самба, оньсон тоглоомууд зааж сургаж байгаа.
- Захчин ардын бий “Хөдөлмөр” “Хүрэн торгот” биелгээ болон товшуур, шагшуурга хөгжимтэй “Үенчийн магтаал” зааж сургалаа.

“Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажил:

1. Багш нар хоорондоо туршлага солилцож нээлттэй үйл ажиллагаа сайжруулан зохион байгуулав.

Ховд сум:

Засаг даргын Тамгын газар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлан ажиллаж байна.

Аймгийн Цагдаагийн байгууллага 2019 онд хийж хэрэгжүүлсэн ажлаа иргэд, албан хаагчдад танилцууллаа. Уг арга хэмжээнд 120 иргэн оролцов.

Орон нутагт хэрэгжүүлсэн ажлыг танилцуулах, сурталчлах, өвөлжилт хаваржилтын байдалтай танилцах ажлын хэсгүүд Засаг дарга, ИТХ-ын дарга, орлогч даргаар ахлуулан хөдөө багуудаар ажиллаж байна.

Хүн ам орон сууцны тооллогод 95 өрх хамрагдан амжилттай зохион байгууллаа. 4 тоологч, 1 хянагч, 1 ахлагч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллав.

Агаарын бохирдлын тооллого зохион байгуулан мэдээг аймгийн УЦУОШГ хүргүүлэв.

Цэргийн тоо бүртгэл явагдаж байна. Аймаг, сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг дүн мэдээг эцэслэн гаргаж 2 сарын 10-с өмнө аймгийн Цэргийн штабт хүргүүлнэ. 18-50 насны эрчүүдийн бүртгэлийг цахимжуулах ажил явагдаж байна.

Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хүнс, хүүхдийн цэцэрлэгийн хүнсний тендер шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан.

Аймгийн ЗДТГ-ын дарга Д.Энхболдоор ахлуулсан ажлын хэсэг ажиллав. 2019 оны ажилд хяналт үнэлгээ хийж, арга зүйн зөвлөгөө өгч аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажлуудыг ард иргэдэд сурталчлан уулзалт зохион байгуулав.

Сургуулийн шинэ барилга, ЭМТ-ийн их засварын зураг гаргасан.

Сумын онцгой байдал коронавирус гарсантай холбоотой хуралдан урьдчилан сэргийлэх, мэдээлэл түгээх ажлуудыг зохион байгуулах шийдвэр гаргав.

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн төвд хэвтсэн өвчтөн 15 үүнээс дотрын тасагт 13, хүүхдийн тасагт 2хэвтэж эмчилгээ хийлгэсэн.

Эрүүл мэндийн яам, ХӨСҮТ-ийн хамтарсан багийн “Тэмбүүг устгая аяны” хүрээнд сумын хэмжээнд нийт 16 хүн шинжилгээнд хамрагдав.

Нас баралт -2, Төрөлт -0, Эмч нарын үзлэг -385, Томуу, томуу төст өвчин-20, Нийт дуудлага -27, Алсын дуудлага-11, Ойрын дуудлага -24, Товлолын вакцинд хамрагдсан хүүхдүүд -44, Өргөдөл гомдол 3 ирсэн шийдвэрлэсэн байгаа.

Чандмань сум:

Нэг. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 2 удаа хуралдаж, аймаг, сумын аварга малчин, төрийн дээд одон медалаар шагнагдах иргэдийг хэлэлцэж, дээд шатанд уламжлан ажиллаа. Үндсэн хуулийн баярт зориулсан Монгол дээлний өдөр, караоке дууны тэмцээн, панжиганы тэмцээн зохион байгуулсан.

Хоёр:Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл:

Тус сумын Засаг даргын Тамгын газар нь жилийн ажлын төлөвлөгөө, дотоод журмын өөрчлөлтийг хийж нэгдсэн төлөвлөгөөгөө батлан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Засаг даргын орлогч Уранчимэгээр ахлуулсан ажлын хэсэгтэй хамтран уулзалтыг зохион байгуулан өвөлжилтийн болон бусад асуудлаар малчид хөдөлмөрчдийн дуу хоолойг сонсож үйл ажиллагаандаа тусган ажиллаа.

Сумын Засаг даргын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнийг 2020 оны 01 дүгээр сарын 18,19-20-ны өдрүүдэд зохион байгуулж аваргуудаа шалгарууллаа.

Сумын Засаг даргын зөвлөл хуралдаж болзол журмын дагуу 2020 оны Аймгийн аварга малчинг шалгаруулж дээд шатанд уламжилсан.

2020 оны 01 сарын 09-15-ны хооронд хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг зохион байгуулж түүвэр судалгаагаар нийт 75 өрх хамрагдаж амжилттай зохион байгуулсан.

Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн Ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх 2018 оны Хууль зүйн сайдын тоот тушаалаар батлагдсан “Иргэний улсын бүртгэл” хөтлөх журмыг хэрэгжүүлэн иргэний гэр бүлийн 8 төрлийн бүртгэлийг иргэдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч холбогдох баримтыг шалган бүртгэлийг хөнгөн шуурхай иргэдэд чирэгдэлгүй үйлчилж байна. Тайлант онд шинээр төрсөн хүүхэд 4, гэрлэлтийн бүртгэл 2, нас баралтын бүртгэл 0, эцэг тогтоолтын бүртгэл 1, овог, эцгийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл 2, иргэний шинэчилсэн бүртгэл буюу хурууны хээ өгсөн 6 иргэн, шилжиж ирсэн 15, иргэний бүртгэлийг хийлээ. Бүртгэл хийсэн маягтуудын аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст тухай бүр хүргүүлэн журманд заасан хугацаанд үндсэн мэдээллийн санд тусгагдан баталгаажсанаар төрөөс олгож байгаа хөдөлмөр халамжийн үйлчилгээтэй холбогдсон тэтгэмжийг олгоход баримт бичгийн зөрчил, хүндрэл гарахгүй байгаа нь ажлын уялдаа холбоо сайжирсантай холбоотой байна

Гурав. Хөдөө аж ахуй, байгаль орчин, газрын харилцааны чиглэлээр:

Байгаль орчин:

Чандмань сумын агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн тоо бүртгэлийг зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.4, 8.1.5 дахь заалтууд, Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны А/822 тоот захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Чандмань сумын Засаг даргын 2020 оны А/03 тоот захирамжаар байгуулагдсан 17 хүний бүрэлдэнүүнтэй ажлын хэсэг нь тус сумын төвийн айл өрх, албан байгууллага, ААН-үүдээр явж агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн тоо бүртгэлийг 01 сарын 22-ны дотор тоолж дуусгасан болно.

Тус сум нь 6 хорьт, 1 дулааны станц, 8 ААН –үүдэд тоологчид хуваагдан тоолж тооллогын үед ямар нэгэн зөрчил илрээгүй боловч хүндрэлтэй бэрхшээлтэй асуудлууд нэлээд гарч байсан.

Тус сумын 6 хорьтын Ард иргэдэд агаарын бохирдолын талаар яриа таниулга мэдээлэл хийж сурталчилсан болно.

Тооллогын дүн мэдээг танилцуулахад сумын төв дээр байгаа агаарын тооллогонд хамрагдсан өрхийн тоо 235 үүнээс 1 хорьт 45 өрх, 2 хорьт 46 өрх, 3 хорьт 41 өрх, 4- хорьт 42 өрх, 5 хорьт 39 өрх, 6 хорьт 25 өрх тус тус тоолсон болно. Нэгдсэн дулааны станцид 6 Төрийн албан байгууллага 3 ААН худалдаа үйлчилгээний цэгүүд, хамрагдсан байна. ААН, худалдаа үйлчилгээний цэгүүд 8, тус тус тооллогдсон байна.

Ердийн галлагаатай 3-15 квт хүчин чадалтай гэрийн зуухны тоо 238 , ААН-үүд, худалдаа үйлчилгээний цэгүүдийн зуухны тоо 8, дулааны станц-1 нийт-246 зуух байна. үүнээс Гэрийн зууханд хэрэглэсэн нүүрсний хэмжээ 819 тн аргал 561,1тн, байшингийн зуухны тоо 61ш үүнээс ханан пиншин 20ш, усан халаалтай зуухны тоо 41ш байна. Байшинтай өрхийн хэрэглэсэн нүүрс 198 тн, Аргал 198 тн тус тус хэрэглэдэг байна.

Хяналт шалгалтын талаар:

Гэмт хэрэгээс урьдчлан сэргийлэх үүднээс амьтаны тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс хяналт шалгалтыг хийхээр төлөвлөсөний дагуу 01 сарын 22-ны өдөр Тамгын газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу загас барьж болох газар нутгуудыг хамруулан хяналт шалгалтыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч С.Жаргалсайхан, Байгаль хамгаалагч нарын хамтаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэлээ Урд, хойт шанаа, Хомын хоолой, Хар нуур, Гахай арал, Үүдэн далай, Цахиуртын хоолой, Үзүүр уул, Их сайр, Бага сайр зэрэг газар нутгуудыг хамруулан хяналт шалгалтыг хийлээ.

Тухайн өдрийн 05 цагийн орчимд Хомын хоолой чиглэлд явж Урд, хойт шанаанаас эхлэн Гахай арал хүртэл нуураар явж засаг барьж болох газруудаар явахад ямар нэгэн зөрчил илрээгүй 16 цагийн орчим Цахиуртын хоолойн орчимд очиход тор татсан шинж тэмдэг илэрч байсан тул нуур, хоолой орчмоор 5 хэсэг болон хулс нуур орчмыг самнаад Цахиуртын хоолой, үзүүр уул зэргээр явж Цахиуртын хоолойд 6 тор татаатай байгааг илрүүлж, орсон загасыг буцаан тавьж торыг нь устгалд оруулаа. Эзэн холбогдогч нь тодорхойгүй учир шалгах мөрдөх ажлыг нь хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай хамтран үргэлжлүүлж байна.

Хөдөө аж ахуй: Хөдөө аж ахуйн тасаг нь Монгол улсын хууль тогтоомж Засгийн газрын тогтоол шийдвэр “Монгол мал” үндэсний хөтөлбөр, Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх биелэлтийг хангах мал сүргийг эрүүлжүүлэх эмчлэн сэргийлэх , газар тариалан хоршоо хоршоологчдын үйл ажиллагааг дэмжих талаар жил, улирлын ажлын төлөвлөгөө боловсруулан

аймгийн ХХААГ–ын даргатай үйл ажиллагааны гэрээ байгуулан сумын Засаг дарга Тамгын газрын даргын удирдлага дор ажлаа явуулж байна. ХАА –н тасгийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг дүгнэн 90,9% -тай дүгнүүлж аймгийн Хяналт үнэлгээний ажлын хэсэгт ажлаа дүгнүүлж ажиллалаа .

МАА 6 багийн 514 малчин өрх өвөлжөөний бүс нутагт нутаглаж байна. 2019-2020 оны өвөлжилтийн байдал цаг агаарын тааламжтай нөхцөл байдлаас шалтгаалан хэвийн ба, 2019 оны жилийн эцэст 6 багийн 532 өрхөд 222238 толгой мал тоолуулсан дүн мэдээтэй байна.

Улс аймгийн аварга малчдыг тодорхойлох ажлыг болзол журмын дагуу зохион байгуулан Улсын аварга малчин –д 2, Аймгийн аварга малчин –д 5, аймгийн Аварга тариаланчид -1 иргэнийг тодорхойлон холбогдох материалыг хугацаанд нь уламжлан ажилласан болно.

Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу үндэсний үйлдвэрт арьс шир тушаасан 471 өрх малчны материалыг бүрдүүлэн холбогдох дээд шатанд хугацаанд нь уламжилсан ба нийт 34385 ш арьс шир тушаасан дүн мэдээтэй байна.

Дөрөв.Нийгмийн бодлогын салбарын үйл ажиллагааны талаархи мэдээлэл:

Хөдөлмөр, халамж үйлчилгээний талаар:

Амьжиргааг дэмжих зөвлөл нь: 2 удаа хуралдаж асаргааны мөнгөн тэтгэмжинд шинээр 2, хугацаа сунгасан 2, улирлын мөнгөн тэтгэмжийн хугацаа сунгасан 2, ахмадын харъяалал тогтоох, хүнсний эрхийн бичгээр үйлчилсэн аж ахуй нэгжид хяналт үнэлгээ хийх зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр:

ЭМТ-ийн бүтэц, орон тоо баталсан байгууллагын даргын 2020 оны А/01 дугаар тушаалыг ажилчдын зөвөлгөөний хуралд танилцуулав. Сумын эрүүл мэндийн төвд шинжилгээнд 96, ЭХО-н оношлогоонд- 56, 70 иргэн амбулаториор үйлчлүүлж, 27 иргэн хэвтэн эмчлүүлж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авсан байна. 1 сарын 22-нд ажилчдын зөвлөгөөний хурал хийж чанарын баг болон халдварын хяналтын баг, бусад багуудыг санал нэгтгэйгээр томиллоо. НЭМ-ийн багуудын ажил хэвийн явагдаж оюутан залуучуудад ЭМ-ийн сургалт хийхийн зэрэгцээ БЗДХ, элэгний В болон С вирусын илрүүлэг, хеликобактерийн шинжилгээнд тус тус 24 оюутан залуусыг хамруулж зөвлөгөө өгсөн. Мөн цэцэрлэгийн багш ажилчдад ЭМ-ийн сургалт хийж 14 ажилчинг хамруулсан.

Хорьтын эргэлт хийж өндөр настан, жирэмсэн эх, 0-5 хүртэлхи насны хүүхдийг эргэж, зөвөлгөө өгч томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага тараасан.

Эрдэнэбүрэн сум:

01 дүгээр сарын 09-15-ны хооронд хүн ам, орон сууцны тооллогын ажлын зохион байгууллаа. Манай сумаас нийт 55 өрх сонгогдож ирснээс хамт өвөлжиж байгаа 3 өрхийг нэмж тоолон нийт 58 өрхийн 233 хүн тоолохоос 211 хүн тоологдож 90.5% нь тоологдсон байна.

Сумын хэмжээнд 2020 онд хийгдэх нийтийг хамарсан ажлын календарчилсан төлөвлөгөө гаргаж батлуулан гаргаж плакатаар хэвлүүлэн бүх байгууллагууд дээр байрлууллаа.

Төрийн байгууллагууд 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулан сумын Засаг даргаар батлууллаа.

Сумын ЭМТ-өөс 01 дүгээр сарын 18-нд сумын хэмжээнд “Мөнгөн өвөл” цас, мөсний баяр, өдөрлөгийн арга хэмжээ зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 120 гаруй хүн хамрагдсан байна.

Сумын Хар ус багийн хурал 01 дүгээр сарын 09-ний өдөр сумын Соёлын төвд болж багийн Засаг дарга Б. Батзаяа 2019 оны үйл ажиллагааны тайлангаа тавьж, цаашдын зорилтын талаар багийн иргэд, хөдөлмөрчдөө танилцуулсан бол МАА-н 4 багийн Засаг дарга нар малчдаараа явж цагийн үеийн асуудлаар мэдээлэл хийж малчдын өвөлжилтийн байдалтай танилцсан байна.

ЕБС-ийн захирал С.Отгончимэг 01 дүгээр сарын 20-нд удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд оролцлоо.

МУ-ын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу арьс, шир бэлтгэх үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий иргэдийн 426 баримт хүлээн авч холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэсэг 01 дүгээр сарын 23-ны өдөр тус суманд ажиллаа. Ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын орлогч Ч. Уранчимэг төрийн албан хаагчид болон иргэд, хөдөлмөрчидтэй уулзалт хийж аймгийн Засаг даргын 2019 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан тавьж, цаашдын зорилтын талаар мэдээлэл хийсэн бол аймгийн Цэргийн штабын офицер хошууч Б. Мөнгөнцоож Монгол улсын Батлан хамгаалахын тухай хууль болон Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай

хууль, Цэргийн албаны тухай хулиудаар мэдээлэл хийж иргэдийн сонирхсон асуултанд хариуллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2019 оны 1/2893 дугаар албан тоотын дагуу сумандаа агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг сумын Засаг даргын 2020 оны А/01 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулж ажиллалаа.

А.Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлд ердийн галлагаатай 3-15 кВт хүртэлх хүчин чадалтай зуухтай 181 айл өрх , үүнээс гэр халаадаг ердийн зуухтай 124, байшин халаадаг ердийн болон ханан пийшин усан халаалттай 57 айл өрх байна.

Б. Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлээр усан халаалтын 15-100 кВт хүртэл хүчин чадалтай зуухтай 3 албан байгууллага байна.

В. Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн тоо бүртгэлээр усан халаалтын 100-4200 кВт хүртэл хүчин чадалтай 1 албан байгууллага байна.

Г. Агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлээр Хар ус багт 105 тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож байна.

2019 онд сумын нэгдсэн төв уурын зуух ашиглалтанд орсноор төвлөрсөн халаалтанд 11 албан байгууллага, аж ахуйн нэгж холбогдсоноор галлах зуухны тоо цөөрч агаарын бохирдлын хэмжээ тодорхой хувиар буурсан гэж үзсэн байна.

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн 28 жилийн ойг тэмдэглэн аймгийн “Цамбагарав” нутгийн зөвлөлөөс жил бүр уламжлал болон зохион байгуулдаг спортын бага наадам 01 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд эрэгтэй, эмэгтэй гар бөмбөг, шатар, теннис, шагайн харваа гэсэн төрлүүдээр өрсөлдөж аваргуудаа тодруулсан байна. Тус тэмцээнд эрэгтэй, эмэгтэй 19 багийн 120 гаруй тамирчид хурд, хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

ЕБС-ийн бага ангийн сургалтын менежер М.Туяатунгалаг аймгийн БСУГ-аас зохион байгуулсан өртөөлчилсэн сургалтанд 01 дүгээр сарын 7-9-ний хооронд Өвөрхангай, Говь-Алтай, Улаанбаатар хотын 24, 21 дүгээр сургуулийн үйл ажиллагаатай танилцан туршлага судлан ажиллалаа.

